**Төрийн өмчит их, дээд сургуулиудын 2013-2015 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит**


**Аудитыг гүйцэтгэсэн:**

Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
М.Наранжаргал

Аудитын менежер:
Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор: Б.Саруул
Шинжээч: Б.Анхбаатар
Б.Хишигтогтох
Б.Мөнхтуяа
Б.Хаш-Эрдэнэ

Нийслэлийн аудитын газрын
Ахлах шинжээч: С.Лхагвасүрэн
Шинжээч: С.Анужин

УАГ-ын Гүйцэтгэлийн болон аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээчид оролцов.

2016 оны 7 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261675, 262451, 263755 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

***Уг тайланг УАГ-ын Веб сайтаас үзнэ үү.*** www.audit.mn

**ХАЯГ:**
Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс


**АГУУЛГА**


Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл ..... 2
Аудитад ашигласан шалгуур ..... 2
Аудитын явцад тулгарсан хүндрэл, бэрхшээл ..... 3
Товчилсон үгийн тайлбар ..... 4
Ерөнхий мэдээлэл ..... 5

**Бүлэг 1. ТӨИДС-иуд сургалтын төлбөрөө нэмэгдүүлэх замаар үйл ажиллагаагаа явуулах санхүүгийн нөөцөөр хангагдаж байгаа ч зарцуулалтад тавих хяналт сул байна**
- Улсын төсвөөс олгож буй санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, үр дүнгийн үнэлгээ сул байна ..... 6
- Хөрөнгө оруулалтыг үндэслэл муутай төлөвлөж, холбогдох хуулийг бүрэн мөрдөөгүйгээс хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна ..... 8
- Сургалтын төлбөрийг тооцох журам, аргачлалыг шинэчлэн сайжруулж мөрдөөгүйгээс тооцооллын үндэслэл муу, төлбөрийн хэмжээг тооцоолох арга, аргачлал, нэгдсэн зохицуулалт дутмаг байна ..... 11
- Сургалтын төлбөр, татаас, бусад орлогыг зарцуулахдаа үр ашиггүй зардал гаргаж, арвилан хэмнэлтийн зарчмыг баримтлахгүй байна ..... 16

**Бүлэг 2. Сургуулиудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тогтолцооны үйлчлэл сул байна**
- Төрөөс баримтлах бодлого, сургуулиудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлэхүйц хэмжээний хугацаа өнгөрөөгүй байна ..... 18
- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, хэрэгжилтэд тавих хөндлөнгийн хяналт сул, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хангалтгүй байна . 21
- Сургалтыг үр нөлөөтэй явуулах материаллаг бааз, шинэ орчин бий болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлжээ ..... 23
- Дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог төлөвшүүлэх, хэрэгжүүлэх талаар сургуулиудын удирдлагын зүгээс хангалтгүй ажиллаж байна .... 24

**Дүгнэлт**: ..... 26

**Холбогдох байгууллагын санал** ..... 27

**Саналд өгсөн тайлбар** ..... 29

**Зөвлөмж:** ..... 30

**Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал** ..... 31

***ХАВСРАЛТУУД:***

***Хавсралт А.*** *Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа* ..... 33
***Хавсралт Б.*** *Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа* ..... 34
***Хавсралт В.*** *ТӨИДС-д суралцагсдын судалгаа* ..... 35
***Хавсралт Г.*** *2013-2015 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын судалгаа* ..... 36
***Хавсралт Д.*** *Санал, асуулгын нэгдсэн дүнгийн нэгтгэл* ..... 37
***Хавсралт Е.*** *Сургалтын төлбөрийн судалгаа* ..... 38
***Хавсралт Ё.*** *Дээд боловсролын салбарт ажиллагсдын судалгаа* ..... 39
***Хавсралт Ж.*** *Орон нутаг дахь ТӨИДС-иудад хийсэн аудитаар илэрсэн төлбөрийн актын жагсаалт* ..... 40
***Хавсралт З.*** *Орон нутаг дахь ТӨИДС-иудад хийсэн аудитаар илэрсэн төлбөр, зөрчил, албан шаардлагын жагсаалт* ..... 41

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

**Аудит хийх үндэслэл**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 оны 05 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт**

“Төрийн өмчит их, дээд сургуулиудын 2013-2015 оны үйл ажиллагаа, үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Төрийн өмчит их, дээд сургуулиуд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй явуулах санхүү, хөрөнгийн нөөцөөр хангагдсан эсэх;
- Төрийн өмчит их, дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тодорхой тусгагдсан зорилт, хөтөлбөртэй эсэх;

**Аудитын хамрах хүрээ**

Аудитад Төрийн өмчит 10 их, дээд сургуулиуд, харьяа эрдэм шинжилгээний байгууллагуудын 2013-2015 оны хичээлийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн баримт материалыг хамрагдлаа.

**Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга, лавлагаа, тайлбар мэдээ гаргуулах, бичгээр тайлбар авч холбогдох нотлох баримтыг гаргуулах, фото зургаар баталгаажуулах, санхүүгийн үйл ажиллагааны болон хяналтын тайлангуудыг судалж, шалгуур үзүүлэлт бодит байдалтай харьцуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитыг хянан баталгаажуулах журам, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

**Аудитад ашигласан шалгуур**

Дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Боловсролын тухай хууль;
- Дээд боловсролын тухай хууль;
- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль;
- Монгол Улсын 2013, 2014, 2015 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Төсвийн тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батласан “Монгол Улсын болон гадаад орны дээд боловсролын сургалтын

байгууллагад суралцагчдад суралцагчийн тэтгэлэг олгох журам”;

- Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгох журам”;
- Шилдэг туршлага ба ЮНЕСКО-гийн олон улсын дээд боловсролын стандарт;
- Бусад эрхийн актууд

**Аудитын явцад тулгарсан хүндрэл, бэрхшээл**

Аудитын явцад дараах хүндрэл бэрхшээл учирч байв. Үүнд:

- Төсөвт зардлын гүйцэтгэлийг Сангийн яамнаас баталсан зардлын ангиллын дагуу тайлагнаж байгаа ч сургуулиудын Удирдах зөвлөлөөс баталсан зардлын ангилал дээрх ангилалтай нийцэхгүй байна.
- Төсвийн гүйцэтгэлийг тайлагнахдаа зарим нэр төрлийн зардлыг жил бүр өөр өөр ангиллаар тайлагнаж байгаа нь зардал бодит дүнгээр тайлагнагдахгүй байх, харьцуулалт, дүн шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж байв.
- Тайлагналын явцад ШУТИС, ХААИС, МУБИС, АШУҮИС, МУИС, ХСИС тус бүрээр тайлан бичиж, бусад сургууль бүрээр танилцуулга бэлтгэн, сургуулиудаас санал авч баталгаажуулсан нь нэгдсэн тайлангийн төслийг бэлтгэхэд хугацаа хоцрох шалтгаан болов.

## ВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| АШУҮИС | Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль |
| БСШУЯ | Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам |
| БСШУС | Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайд |
| БШУС | Боловсрол, Шинжлэх Ухааны Сайд |
| БАС | Барилга, архитектурын сургууль |
| БИАС | Барилгын инженер, архитектурын сургууль |
| БУА | Барилга угсралтын ажил |
| БХИС | Батлан Хамгаалахын Их Сургууль |
| ГАГ | Гүйцэтгэлийн аудитын газар |
| ГУУС | Геологи, уул уурхайн сургууль |
| МХТС | Мэдээлэл холбооны технологийн сургууль |
| МУБИС | Монгол Улсын Боловсролын Их Сургууль |
| МУИС | Монгол Улсын Их Сургууль |
| МГХТДС | Монгол-Германы хамтарсан Технологийн дээд сургууль |
| НББТХ | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль |
| НЗД | Нийслэлийн Засаг дарга |
| НМХГ | Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СУИС | Соёл, Урлагийн Их Сургууль |
| ТАХ | Төсөл арга хэмжээ |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТДС | Тээврийн Дээд Сургууль |
| ТИС | Техникийн Их Сургууль |
| ТӨИДС | Төрийн өмчит их, дээд сургууль |
| ТӨХ | Төрийн өмчийн хороо |
| ТЭЗҮ | Техник, эдийн засгийн үндэслэл |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ХААИС | Хөдөө Аж Ахуйн Их Сургууль |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ХБНГУ | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс |
| ХИС | Ховд Их Сургууль |
| ХСИС | Хууль Сахиулахын Их Сургууль |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| “УБТЗ” ХНН | “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг |
| УА | Удирдлагын академи |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ҮТС | Үйлдвэрлэлийн технологийн сургууль |
| ШУТИС | Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль |
| ЭХИС | Эрчим хүчний их сургууль |
| ЭЕШ | Элсэлтийн ерөнхий шалгалт |

Дэлхийн эдийн засгийн форумаас[1] жил бүр хэвлэн нийтэлдэг дэлхийн улсуудын өрсөлдөх чадварын индексийн 5 дугаар тулгуур үзүүлэлт болгон дээд боловсрол, мэргэжлийн сургалтын чанарыг авч үздэг бөгөөд дээрх үзүүлэлтээр Монгол Улс 2016 онд 2012 оны түвшингээс 50 байраар урагшилж, онооны үзүүлэлт 1.46 пунктээр ахисан байна.

Монгол улсын өрсөлдөх чадварын сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал,

| ҮЗҮҮЛЭЛТ | | 2011-2012 | 2012-2013 | 2013-2014 | 2014-2015 | 2015-2016 |
|---|---|---|---|---|---|---|
| Судалгаанд хамрагдсан нийт улсын тоо | | 142 | 144 | 148 | 144 | 140 |
| Монгол Улсын өрсөлдөх чадварын зэрэглэл | Байр | 96 | 93 | 107 | 98 | 104 |
| | Оноо | 3.86 | 3.9 | 3.7 | 3.8 | 3.8 |
| Тулгуур үзүүлэлт 5. Дээд боловсрол ба мэргэжлийн сургалт | Байр | 112 | 83 | 82 | 68 | 62 |
| | Оноо | 3.04 | 4.0 | 4.1 | 4.4 | 4.5 |

Улсын хэмжээнд 2015 оны байдлаар нийт 100 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаагаас 17 нь төрийн өмчийн, 78 нь хувийн, 5 нь гадаадын их, дээд сургуулийн салбар сургууль байгаагаас Улаанбаатар хотод 91, хөдөө орон нутагт 9 сургууль үйл ажиллагаа явуулж байна.

| ҮЗҮҮЛЭЛТ | | | Сүүлийн 5 жилээр | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2011-2012 | 2012-2013 | 2013-2014 | 2014-2015 | 2015-2016 |
| Нийт дээд боловсролын | | *Сургалтын байгууллагын тоо* | 101 | 99 | 100 | 101 | 100 |
| | | *суралцагсдын тоо* | 172,403 | 175,104 | 174,075 | 178,295 | 162,626 |
| Үүнээс: | Төрийн өмчийн | *сургуулийн тоо* | 15 | 15 | 16 | 16 | 17 |
| | | *суралцагсдын тоо* | 104,101 | 105,751 | 101,855 | 103,650 | 95,033 |
| | Төрийн бус өмчийн | *сургуулийн тоо* | 81 | 79 | 79 | 80 | 78 |
| | | *суралцагсдын тоо* | 68,302 | 69,353 | 71,689 | 74,233 | 67,276 |
| | Гадаадын их, дээд сургууль | *сургуулийн тоо* | 5 | 5 | 5 | 5 | 5 |
| | | *суралцагсдын тоо* | | | 531 | 412 | 317 |

Сүүлийн 5 жилийн статистик үзүүлэлтээс харахад төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургууль, тэдгээрт суралцагсдын тоо харьцангуй тогтвортой байсан боловч 2015-2016 оны хичээлийн жилд 5 жилийн дунджаас 5.7 хувиар буурсан нь 2015-2016 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн тоо өмнөх жилээс 1.9 хувиар буурсан, эдийн засгийн тогтворгүй байдлаас шалтгаалж хүн амын төлбөрийн чадвар муудсан зэргээс их, дээд сургуульд элсэн суралцагсдын тоо өмнөх оны түвшинтэй харьцуулахад 14.8 мянган суралцагчаар буюу 33.8 хувиар багассантай холбоотой байна.

Өмчлөлийн хэлбэрээр 2015 оныг 2012 онтой харьцуулахад нийт суралцагсдын тоонд ТӨИДС-д суралцагчдын эзлэх хувь 1.94 пунктээр буурч, тэр хэмжээгээр төрийн бус өмчлөлийн сургуульд суралцагсдын эзлэх хэмжээ нэмэгджээ.

2015 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчийн 17 сургуульд 95.0 мянган оюутан буюу нийт суралцагчдын 58.4 хувь, төрийн бус өмчийн 78 сургуульд 67.3 мянган оюутан буюу 41.4 хувь, гадаадын их, дээд сургуулийн 5 салбарт 0.3 мянган оюутан буюу 0.2 хувь нь суралцаж байна.

[1] *Эх сурвалж:* www.weforum.org

| Дүгнэлт 1 | ТӨИДС-иуд сургалтын төлбөрөө нэмэгдүүлэх замаар үйл ажиллагаагаа явуулах санхүүгийн нөөцөөр хангагдаж байгаа ч зарцуулалтад тавих хяналт сул байна |
|---|---|

***Улсын төсвөөс олгож буй санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, үр дүнгийн үнэлгээ сул байна***

1.1 ТӨИДС (цаашид сургуулиуд гэх)-иудад улсын төсвөөс тогтмол зардал, хөрөнгө оруулалтын санхүүжилт олгохтой холбоотой дараах эрх зүйн заалтууд хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

- *Боловсролын тухай хуулийн 40.1-т “Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлнэ”, 40.2-т “Төрийн өмчит бүх шатны сургуулийн тогтмол зардал, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны нийт зардал, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, ерөнхий боловсролын албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох сургалтын нормативт зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ”;*
- *Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5.6-д “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн хөрөнгийг бүрдүүлэх, шинэчлэх, өргөтгөхтэй холбогдох хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс санхүүжүүлнэ”*
- *ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48.1-д “Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ”*
- *Боловсролын тухай хуулийн 39.4-т “Боловсролын байгууллагын өөрийн орлогын хэмжээтэй холбоотойгоор улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг багасгахыг хориглоно” гэж тус тус заасан байна.*

1.2 2013-2015 оны хичээлийн жилд төрийн өмчийн 12 их, дээд болон түүний харьяа сургуулиудын тогтмол зардал, хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэлд улсын төсвөөс 30.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгожээ. *(Дэлгэрэнгүйг хавсралт А,Б-гээс үзнэ үү)*

*Хүснэгт 1.ТӨИДС-иудын тогтмол зардал, хөрөнгө оруулалт* *(сая төгрөг)*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2013-2014 он | | | | 2014-2015 он | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Улсын төсвөөс *санхүүжсэн* | | Бодит гүйцэтгэл | | Улсын төсвөөс санхүүжсэн | | Бодит гүйцэтгэл | |
| | Хөрөнгө оруулалт | Тогтмол зардал | Хөрөнгө оруулалт | Тогтмол зардал | Хөрөнгө оруулалт | Тогтмол зардал | Хөрөнгө оруулалт | Тогтмол зардал |
| Аудитад хамрагдсан сургуулиудын дүнгээр | **3,623.8** | **5,083.3** | **12,238.7** | **6,683.7** | **17,669.7** | **4,177.0** | **16,130.2** | **7,682.7** |

Эх сурвалж: ТӨИДС-иудын сургалтын жилээрх орлого, зардлын тайланд суурилав.

1.3 Сургуулиудаас Орхон аймаг дах Технологийн дээд, УБТЗ ХНН-ийн харьяа Тээврийн дээд сургуулиуд улсын төсвөөс санхүүжилт авдаггүй, Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт үйлдвэр” ХХК, УБТЗ ХНН-ийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдэж, татаас, санхүүжилт нь дээрх байгууллагуудаас хийгддэг бөгөөд мэргэшилтэй боловсон хүчин бэлтгэх бааз хэлбэрээр сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

***Тогтмол зардлын санхүүжилтийг бодит зардлаар тооцоогүй, эрх бүхий байгууллагаас бүрэн хэмжээнд санхүүжүүлээгүй байна***

1.4 Сургуулиудад олгож буй тогтмол зардлын санхүүжилт гүйцэтгэлээс 2013-2014 оны хичээлийн жилд 1,600.4 сая төгрөг буюу 31.5 хувь, 2014-2015 онд 3,505.7 сая төгрөг буюу 86.6 хувиар бага байна. Өглөгийн хэмжээг сургууль тус бүрээр дүрслэл 1-д үзүүлэв.

1.5 БСШУЯ-наас сургуулиудад тогтмол зардлын санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгоогүйгээс өглөг жилээс жил нэмэгдэж, өглөгийн хэмжээ 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 4.7 тэрбум төгрөгт хүрчээ.

*Дүрслэл 1. ТӨИДС-иудын тогтмол зардлын санхүүжилтийн өглөг (сая төгрөг)*




1.6 БСШУЯ тогтмол зардлыг санхүүгийн жилийн эцэст гүйцэтгэлээр тооцоо нийлж, өглөгийг актаар баталгаажуулдаг боловч зардлыг нэр, төрлөөр тулган баталгаажуулдаггүйгээс дулааны тоолуурын үнэ, баталгаажуулалтын хөлс, засвар үйлчилгээ, гэмтэл оношлогооны гэх мэт зардлыг тогтмол зардлын дунд оруулан нэхэмжилснийг хасч тооцоогүй, сургуулийн байранд талбай түрээслэгчид, дотуур байранд амьдрагч айлуудын хэрэглээний тогтмол зардал улсын төсвөөс төлөгдөж, зарим сургуулиуд бусад орлогын эх үүсвэр болгон ашиглаж байна. Тухайлбал,

- *ШУТИС-ийн МХТС 2013-2015 онд нийт 13.1 сая төгрөгийн бусад зардлыг тогтмол зардалд тооцон улсын төсвөөс санхүүжилт авсан.*
- *ХААИС орон сууцны хэрэглэгчдийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлын 2013 онд 70.9 сая, 2014 онд 58.5 сая, 2015 онд 103.9 сая, нийт 233.2 сая төгрөгийг улсын төсвөөс авах тогтмол зардлын санхүүжилтэд оруулан тооцсон байна.*
- *АШУҮИС-ийн төв байранд "Морс трэйд" ХХК 2014 оны 9 дүгээр сараас эхлэн 187м$^2$ талбайг оюутны цайны газрын зориулалтаар сарын 2,440.0 мянган төгрөгөөр ТӨХ-той хамтарсан 3 талт гэрээгээр түрээслэн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд цахилгаан, цэвэр бохир ус ашигласны төлбөрөө сар бүр тоолуурын заалтаар баталгаажуулан 2014-2015 онд 2.9 сая төгрөг төлсөн боловч төсвөөс авах санхүүжилтээс суутган тооцоогүй;*
- *МУБИС-ийн хичээлийн болон оюутны байруудад үйл ажиллагаа явуулж буй түрээслэгч аж ахуйн нэгжүүдтэй ТӨХ-ны 2007 оны 42 дугаар тогтоолын жишиг үнийг баримтлан 3 талт гэрээ байгуулдаг бөгөөд уг үнэд ашиглалтын зардлыг оруулж тооцдоггүй, түрээслэгч нар тусдаа тоолуургүйгээс ашиглалтын зардлыг тооцох боломжоор хангагдаагүй;*
- *ШУТИС-ийн оюутны 4 байранд нийт 85 айл амьдарч байгаа бөгөөд тоолуургүй, 3 байранд амьдарч буй айлуудаас цахилгааны төлбөрт сард 12.5-20.0 мянган төгрөг тогтмол авдаг, МХТС-ийн дотуур байранд суух 22 айлаас цахилгааны төлбөрт 2013-2014 он, 2015 оны эхний хагас жилд нийт 6.3 сая төгрөгийг авсан ч суугчдаас авсан цахилгааны зардлыг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх, суутган тооцох талаар журамлаагүйгээс төсвөөс олгож буй санхүүжилтийг жилд ойролцоогоор 15.0 сая төгрөгөөр хэмнэх боломжийг алдсан байна.*

1.7 Эдийн засгийн ойлголтоор үйл ажиллагааны түвшин, үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаарч өөрчлөгддөггүй, нэгж бүтээгдэхүүний хувьд хувьсах шинж чанартай зардлуудыг тогтмол зардлаар нэрлэж, уг зардалд удирдлагын цалин хөлс, патент, даатгалын болон харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ, засвар, ус, цахилгаан, дулааны гэх мэт зардлуудыг тооцохоор байна.

1.8 Мөн Засгийн газрын 1998 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "*төсөвт зардлын зарцуулалтын үр дүнг тооцох журам*"-д зааснаар "... байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, ажил, үйлчилгээний хэмжээ, үр дүнгээс шууд хамаарахгүй орон байрны ашиглалттай холбогдсон дулаан, эрчим хүч, цэвэр, бохир, халуун ус болон бусад нийтлэг хэрэглээний" зардлыг тогтмол зардлаар тооцдог байна.

1.9 Гэвч дээрх сургуулиудад тогтмол зардлын санхүүжилтийг зөвхөн орон байрны ашиглалттай холбоотой зардалд олгож, БСШУЯ-наас сургуулиудад олгох тогтмол зардлын санхүүжилтийн сар, улирлын хуваарийг гарган хүргүүлдэггүй, зарим сургуулиуд зардлын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлийг харгалзаж байхад зарим нь хэт өндрөөр төлөвлөж цахилгаан, дулааны зардлыг нийлүүлэгчдэд шилжүүлсэн дүнгээр тооцоо нийлж санхүүжилтийг авч байгаа нь нэрлэсэн тогтмол зардлын санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт сул байгааг харуулж байна.

1.10 Сургуулиудын санхүүгийн тайлангаас үзэхэд тогтмол зардал дунджаар нийт орлогод 4.0 хувь, нийт зардалд 3.8 хувь, хөрөнгийн чөлөөт үлдэгдэлд 8.0 хувийг эзэлж, сургуулиудын хувьд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нөлөөлөх нөлөөлөл харьцангуй бага байна.

***өнгө оруулалтыг үндэслэл муутай төлөвлөж, холбогдох хуулийг бүрэн мөрдөөгүйгээс хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна***

1.11 ТӨИДС-иуд тухайн онд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг хуульд заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөхгүй байна.

1.12 Сургуулиудад сүүлийн 3 жилд улсын төсвөөс 25.0 тэрбум төгрөгийн ажил хийгдэж, сургуулийн материаллаг орчин сайжирч, сургалт судалгаа явуулах лаборатори, туршилтын цехүүд нэмэгдэж суралцах үйл явцад үр нөлөөгөө үзүүлж байна. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг эх үүсвэрээр харуулбал,

*Хүснэгт 2. Улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн санхүүжилтийн эх үүсвэр (сая төгрөг)*

| Хөрөнгийн эх үүсвэр | 2013 он | | | 2014 он | | | 2015 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төл | Гүйц | Зөрүү | Төл | Гүйц | Зөрүү | Төл | Гүйц | Зөрүү |
| Улсын төсвийн хөрөнгө оруулалт | | | | | | | 3,919.4 | 1,887.6 | 2,031.8 |
| БСШУС-ын багцын их, дээд сургуулийг дэмжих хөрөнгө | 398.1 | 197.8 | 200.3 | 6,000.0 | 5,179.5 | 820.5 | 1,080.1 | 579.8 | 500.3 |
| АХБ-ны Дээд боловсролын шинэчлэл төсөл | 7,329.2 | 5,428.2 | 1,901.0 | 10,061.6 | 8,422.9 | 1,638.7 | 4,000.0 | 2,271.7 | 1,728.3 |
| Японы ЗГ-ын тусламжийн сургуулийн барилгын өргөтгөл төсөл | | | | 156.6 | 154.0 | 2.6 | 200.0 | | 200.0 |
| Японы Өвсний үндэс хөтөлбөр | | | | | | | 100.0 | 95.0 | 5.0 |
| Дэлхийн зөн ОУБ-ын тусламж (монголын талын хөрөнгө) | | | | 1,055.5 | 811.2 | 244.3 | | | |
| **Нийт дүн** | **7,727.3** | **5,626.0** | **2,101.3** | **17,273.7** | **14,567.6** | **2,706.1** | **9,299.5** | **4,834.1** | **4,465.4** |
| Хэрэгжилтийн хувь | | | 72.8 | | | 84.3 | | | 52.0 |

1.13 Сургуулиуд босго үнэ давсан ажилд шууд гэрээ байгуулах, холбогдох бэлтгэл бүрэн хангагдаагүй үед ХАА зохион байгуулж байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1[2], 29.4[3], 33.1[4], 33.2.1[5], Барилгын тухай хуулийн 13.2[6] дах заалтуудыг зөрчсөн, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримтлаагүй байна. Тухайлбал,

- *ХИС босго үнээс давсан 14 ажилд шууд гэрээ байгуулсан;*
- *Дорнод их сургууль 2013 онд 198.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сургуулийн дээврийн засварын ажлын зураг, төсөвт магадлал хийлгэлгүйгээр тендерийг зарлаж, гүйцэтгүүлсэн;*
- *МУБИС-ийн Архангай аймаг дах Багшийн сургууль 68.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ажилд харьцуулалтын аргыг ашиглалгүйгээр шууд гэрээ байгуулсан;*

*[2] Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно. 8.1.1.харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар; 8.1.2.шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;8.1.3.зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;*

*[3] Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон ТАХ-г тусгана.*

*[4] Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.*

*[5] техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх;*

*[6] Гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, эсвэл газар хөдлөлтийн 6-гаас дээш баллын бүсэд баригдах барилга, байгууламжийн зураг төсөл, инженер-геологийн төвөгшилтэй нөхцөлийн судалгааны дүгнэлт, ТЭЗҮ-д магадлал заавал хийлгэнэ.*

- *МУИС-ийн Орхон аймаг дах салбар сургууль 2013 онд Ивээлт Оргил ХХК-тай шууд гэрээ байгуулан 32.0 сая төгрөгийн засварын ажил хийхдээ 15.8 сая төгрөгийг ерөнхий нягтлан бодогч бэлнээр авч гүйцэтгэгчид төлсөн гэх боловч мөнгөний баримтад гарын үсэг зурагдаагүй, нийт дүнгээр ажлын гүйцэтгэлд 34.0 сая буюу 2.0 сая төгрөгийг илүү олгосон;*
- *АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дах салбар сургууль 2013-2014 онд 152.8 сая төгрөгийн худалдан авалтыг сонгон шалгаруулалтгүйгээр хийсэн;*
- *АШУҮИС-ийн Дорноговь аймаг дах салбар сургууль 2014-2015 онд 82.6 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахдаа тендер шалгаруулалтын журмыг мөрдөөгүй шууд худалдан авалт хийсэн;*
- *АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дах салбар сургууль 2013 онд 154.6 сая, 2014 онд 237.6 сая төгрөгийн босго үнэ давсан худалдан авалтыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.*

1.14 Сургуулиудын захиргаа, БСШУЯ-ны холбогдох албад хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүйгээс улсын төсөв, сургуулийн өөрийн хөрөнгөөр санхүүжсэн ТАХ-үүдийн хэрэгжилтийн явц удааширсан, ажил дүгнэж гүйцэтгэлийн акт үйлдэхгүй байх, чанаргүй хийгдэх, ажлын тоо дутуу, өндөр үнээр худалдан авалт хийх зэрэг алдаа илэрч байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна. Тухайлбал,

- *АШУҮИС оюутнуудын чөлөөт цагаа өнгөрөөх тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор 2014 оны төсвийн тодотголоор БСШУС-ын багцаас 330.4 сая, өөрийн эх үүсвэрээр 140.0 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэн "Оюутны Эко цогцолбор төв"-ийн барилгын ажлыг эхлүүлсэн боловч гүйцэтгэгч "Шил металл хийц" ХХК гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүйгээс, гэрээнд заагдсан ажлыг 2015 оны 5 дугаар сарын 15-ны дотор хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөх, эсвэл захиалагчаас анх шилжүүлсэн 438.0 сая төгрөг, хугацаа хожимдуулсан алданги болох 80.0 сая төгрөгийн хамтаар үл маргах журмаар төлөхөөр шүүхээр шийдвэрлэсэн боловч хэрэгжилт хангагдаагүй;*
- *АШУҮИС лаборатори байгуулах зориулалтаар өөрийн хөрөнгөөр 338.8 сая, лабораторийн санхүүжилтээс 79.8 сая төгрөгийг тус тус зарцуулж, тохижуулсан боловч 2013 онд барилгын зориулалтыг өөрчилж дахин гэрээ байгуулахдаа Барилгын тухай хуулийн 16.6[7] 20.2[8] дах заалтыг мөрдөж ажиллаагүй тул улсын комисс ашиглалтад хүлээж аваагүй, барилгын дотор халаалт дулааны асуудал шийдэгдээгүй, ажилтнууд хүйтэн орчинд ажиллаж байна.*
- *АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дах салбар сургууль 2014 онд спорт заалны засварыг 3 компаниар нийт 88.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч гүйцэтгэл нь чанарын шаардлага хангаагүй;*
- *ХИС улсын төсвийн хөрөнгө оруулалтаар оюутны 1, 2 дугаар байрны гадна фасад, цонх, гадна хаалгыг солихоор ББМЗЗТ ХХК-иар зураг, төсөв хийлгэсэн боловч тендерийг зарлахдаа ажлын тоо хэмжээг өөрчилж сантехникийн ажил болгосон;*
- *ХИС явган зам байгуулах ажилд цементийг өөрийн хөрөнгөөр худалдан авч гүйцэтгэгч Панцас ХХК-д олгосноор 2.7 сая төгрөгийн давхар зардал гаргасан.*
- *ХИС АХБ-ны дэмжлэгээр 2014 онд БСШУЯ-наас олгосон нийт 371.0 сая төгрөгийн санхүүжилтээс 41.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг одоог хүртэл хүлээн аваагүй. Мөн бордооны үйлдвэр байгуулахаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 63.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан боловч ашиглалт хангалтгүй, зарим тоног төхөөрөмжийг аваагүй, гадаа ил задгай байрлуулснаас ашиглалтын хугацаа багасах, бүтээгдэхүүн үйлдвэрлэж гаргасан гэх боловч хэдий хэмжээний бордоо үйлдвэрлэж зах зээлд нийлүүлсэн нь тодорхой бус байна.*
- *ХИС-аас 2014 онд багш, ажилчдын орон сууцны барилгыг Сэнзо констракшин ХХК-тай 27.5 сая төгрөгийн гэрээг тус тус байгуулан гүйцэтгүүлсэн, геологи хайгуулын ажлыг Хан хошууд ХХК-тай 4.0 сая төгрөгийн гэрээ байгуулан хийлгүүлсэн боловч дээрх арга хэмжээнүүдийг хэззэ хэрэгжүүлэх нь тодорхой бус;*
- *АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дах салбар иргэнээс 16gb багтаамжтай флаш диск 100 ширхэгийг 1 бүрийг нь 60.0 мянган төгрөгөөр худалдан авсан.*
- *МУБИС 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БСШУЯ-наас эрх шилжүүлсэн "Сургуулийн өмнөх боловсролд зориулсан хөгжмийн зэмсэг худалдан авах ТТ-2014-88" гэрээг Фүлсолюшн ХХК-тай байгуулж, зах зээлийн үнээс 1-49 дахин өндөр үнээр хөгжмийн зэмсэг худалдан авсан зэрэг алдааг нэрлэж болохоор байна.*

***Сургалтын төлбөрийн орлогоос томоохон хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь сургалтын төлбөртөө уг зардлын санхүүжилтийн тодорхой хувийг нэмж төлсөн оюутны суралцах хугацаанд ашиглагдахгүй байна***

1.15 Аудитад хамрагдсан сургуулиуд 2013-2015 оны хичээлийн жилүүдэд сургалт, судалгаа эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулах байр бэлтгэх, номын сан барих зэргээр нийт 12.2 тэрбум төгрөгийг томоохон хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан нь "Дээд боловсролын

---

*[7] Барилга угсралтын ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр эхлэх, үргэлжлүүлэхийг хориглоно.*
*[8] Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учруулах, зохих мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүтэц, төлөвлөлт, зориулалтыг өөрчлөх, тухайн барилга байгууламж дотор байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.*

хүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль"-ийн д 5.6[9] дах заалттай зөрчилдөж байна. Тухайлбал,

- *АШУҮИС 2014 онд 3,099.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Төв номын сангийн барилгад улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2014–2015 онд 1,900.0 сая төгрөг, сургуулийн хөрөнгөөс 1,100.0 сая төгрөгийг тус тус санхүүжүүлж, 2015 оны 12 дугаар сарын 08-нд улсын комисс хүлээн авч ашиглалтад орсон;*
- *ХААИС 2015 оноос баригдаж эхэлсэн 6,634.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй спорт заал, зоорийн давхар бүхий 4 болон 10 давхар хичээлийн 2 байртай 3 блокоос бүрдэх хичээлийн 2 дугаар байрны санхүүжилтэд зориулж 2015 онд 1,100.0 сая, 2016 онд 400.0 сая төгрөгийг төсөвлөж, 2015 онд буцаан төлөх нөхцөлтэйгээр 393.7 сая төгрөгийг Стройка ХХК-тай албан ёсны гэрээ хэлцэлгүйгээр олгосон;*
- *МУБИС 5,928.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сургалт, судалгааны төвийн барилгын санхүүжилтэд 2014 онд сургуулийн өөрийн хөрөнгөнөөс 3,000.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн;*
- *МУИС номын сан, хичээлийн 4 дүгээр байрны өргөтгөлийн 16.6 тэрбум төгрөгийн өртөгтэй барилгын БУА-ын гүйцэтгэлд улсын төсвөөс 3.6 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, 2016 оны 4 сарын 30-ны байдлаар өөрийн хөрөнгөнөөс 11,157.8 сая төгрөгийг олгосон гэх мэт.*

***ХАА-г олон жижиг хэсэгт хуваасан, тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн зэрэг нь санхүүгийн болон худалдан авалтын үр ашгийг бууруулж байна***

1.16 МУБИС засвар, тохижилтын ажлуудыг олон жижиг ажил болгон төлөвлөн ХАА-г зохион байгуулж ирсний дээр гэрээг байгуулахдаа ХАА-ны үр дүнгээр бус төсөвлөсөн дүнгээр байгуулж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1.4[10]-д заасан төсөв хэмнэх боломжийг алдсан байна. 2013-2014 онд улсын төсвийн хөрөнгөөр 2,694.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, бүгд 52 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг дээрх аргаар хэрэгжүүлсэн байна.

1.17 Мөн харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа зарим тендерт оролцогчдод өгөх зааварчилгаанд тендерийн иж бүрдэлд шаардлагатай тусгай зөвшөөрөлтэй байх ёстой гэсэн боловч 730.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг зөвшөөрөлгүй компаниудаар гүйцэтгүүлсэн нь цаг хугацаа алдах, ажил чанаргүй хийгдэх, үр ашиггүй зардал гарах эрсдэлийг бий болгожээ. Тусгай зөвшөөрөлгүй ажил гүйцэтгэсэн компаниудын нэрсийг дурдвал,

- *Тэму холдинг ХХК 35.0, 45.0 сая төгрөгийн 2 засварын;*
- *Ди Ти Эм Ти ХХК 76.0 сая төгрөгийн тохижилтын;*
- *Бэхийн өндөр ХХК 33.0, 40.0 сая төгрөгийн засварын;*
- *Примервиндоу ХХК нийт 130.0 сая төгрөгийн 2 засварын;*
- *Айсинет ХХК 32.4, 36.5, 52.4 сая төгрөгийн дэд бүтцийн шинэчлэлтийн;*
- *Өгөөмөр нутаг ХХК 65.7, 35.5, 49.2 сая төгрөгийн харилцаа холбооны дэд бүтцийн шинэчлэлтийн;*
- *И Эс Пи Эм Эн ХХК 35.0 сая төгрөгийн дээврийн засварын;*
- *Ажлын цаг ХХК 22.4 сая төгрөгийн зам талбайн тохижилтын;*
- *Хөх харгай эхэн ХХК 41.5 сая төгрөгийн дээврийн засварын ажлуудыг тус тус гүйцэтгэсэн.*

1.18 Аудитад хамрагдсан хугацаанд ТӨИДС-иудын зарим хөрөнгө оруулалтыг, тогтмол зардлын зарим хэсгийг сургалтын төлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлсэн нь Боловсролын тухай хуулийн 40.2, 40.7, Дээд боловсролын санхүүжилт, суралцагсдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5.6 дах заалттай нийцэхгүй байна.

***Сургалтын төрийн сангаас олгож буй зээл, тусламж, тэтгэлгээр суралцагчдын тоо 2015 онд 2013 онтой харьцуулахад 2.1 дахин буурчээ***

1.19 Сургалтын төрийн сангаас улсын хэмжээнд 2013 онд 178,804 оюутанд 115.3 тэрбум, 2014 онд 168,959 оюутанд 100.3 тэрбум, 2015 онд 85,476 оюутанд 37.7 тэрбум төгрөгийн 9 нэр, төрлийн зээл, буцалтгүй тусламж, тэтгэлэг олгосон байна. 2015 оныг 2013 онтой харьцуулахад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж авах оюутны тоо 2.1 дахин, олгож буй санхүүжилт 3.1 дахин буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- *Засгийн газрын 2000 оны 201 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх" журмын дагуу олгож, тэтгэлэгт хамрагдагсдын тоо 2013 онд 11,489, 2014 онд 10,677, харин 2015 онд 2,685 болж буурсан нь уг тэтгэлгийг Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор хүчингүй болгосонтой холбоотой бөгөөд 2015 оны байдлаар тэтгэлгээр суралцагсдын суралцах хугацаа дуусгавар болж байна.*

---

*[9] Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн хөрөнгийг бүрдүүлэх, шинэчлэх, өргөтгөхтэй холбогдох хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.*
*[10] 46.1.4 худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;*

*Багш бэлтгэх тогтолцоог шинэчлэн чанартай багш бэлтгэх, багш болох авьяас сонирхолтой хүүхдийг нээн илрүүлэхэд төрийн зүгээс бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүднээс Боловсролын тухай хуулийн 40.6-д[11] заасны дагуу Засгийн газрын 2013 оны 181, 2014 оны 71 дүгээр тогтоолоор ТӨИДС-д багш мэргэжлээр элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан оюутнуудад сургалтын төлбөр, багшлах дадлагын тэтгэлэг олгож байгаа ба 2014 оноос хойш төсвийн хүндрэлээс шалтгаалан санхүүжилт олгогдоогүй байна.*

***Санал асуулгын дүн:*** *Нийт 1,887 ажилтан "**Сургуулиудын хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагаа үр нөлөөтэй хэрэгждэг үү?**" гэсэн асуулгад 63 хувь нь мэдээлэл хүрдэггүй, 23 хувь нь тийм, 14 хувь нь үр нөлөөгүй гэж хариулжээ. Энэ нь хөрөнгө оруулалтын үр нөлөөнд хэрэглэгчид сэтгэл ханамжгүй, хэрэглэгчдэд ил тод, нээлттэй явагдаж чадахгүй байгааг харууллаа.*

1.20 Сургуулиуд төрөөс олгож байгаа санхүүгийн дэмжлэгийг арвилан хэмнэлттэй ашиглах талаар санаачлага гаргаагүй, санхүү, нягтлан бодох бүртгэлээрх үр дүнгийн үзүүлэлтүүд БСШУЯ-ны мэдээллээс зөрүүтэй, төсвийн дэмжлэг, хөрөнгийг ашигласнаар сургуульд үзүүлж буй үр нөлөөт байдлын талаар хийсэн судалгаа БСШУЯ болон ТӨИДС-иудад алга байна.

***Сургалтын төлбөрийг тооцох журам, аргачлалыг шинэчлэн сайжруулж мөрдөөгүйгээс тооцооллын үндэслэл муу, төлбөрийн хэмжээг тооцоолох арга, аргачлал, нэгдсэн зохицуулалт дутмаг байна***

1.21 БСШУЯ-ны статистик үзүүлэлтээс харахад улсын хэмжээнд их, дээд сургуульд жилд дунджаар 171.7 мянган оюутан суралцаж байгаагаас 52.7 хувь нь тухайн хичээлийн жилийн эхэнд төлбөрөө төлдөг байна. Нийт суралцагчдын 90.0 хувь нь хувийн зардлаар, 7.0 хувь нь Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр, 0.4 хувь нь тухайн сургуулийн зардлаар, үлдэх 3.0 хувь бусад нь эх үүсвэрээр суралцдаг.

1.22 ТӨИДС-иудын сургалтын төлбөрийг хувийн их, дээд сургуультай харьцуулахад 1.5-6.5 пунктээр бага байна.

1.23 Харин дотоодын зарим ерөнхий боловсролын сургуулийн (хувийн) сургалтын төлбөр ТӨИДС-иудын төлбөрөөс 2.5-17.5 дахин илүү гэсэн үзүүлэлт гарч байна.

*Судалгаа 1.Сургалтын төлбөрийн дундаж (сая төгрөг)*

| Үзүүлэлт | | 2013-2014 | 2014-2015 | 2015-2016 |
|---|---|---|---|---|
| Сургалтын төлбөрийн дундаж | ТӨИДС | 1,273.3 | 1,491.8 | 1,788.8 |
| | Бусад их, дээд сургуулиуд | 1,292.3 | 1,595.1 | 1,842.3 |

1.24 Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11.4[12]-т заасныг үндэслэн сургуулиудын удирдах зөвлөл сургалтын төлбөрийн хэмжээг тогтоож байна. Аудитад хамрагдсан 2013-2015 онуудад сургуулиудын удирдах зөвлөл сургалтын төлбөрийг жил бүр нэмэгдүүлсэн байна.

1.25 Гэгээрлийн сайд (хуучин нэрээр)-ын 1999 оны 107 дугаар тушаалаар батлагдсан "*Их сургууль, коллежийн төсөв зохиох, сургалтын төлбөрийг тодорхойлох үлгэрчилсэн аргачлал*"-д хувийн болон улсын их сургууль, коллежийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрээр нь ангилж, сургалтын төлбөрт хамаарах зардлын нийт дүнг өдрийн ангид шилжүүлсэн оюутны тоог жилд нэг оюутны цуглуулах кредит цагийн үржвэрт харьцуулж гаргасан нэг кредит цагийн үнэлгээг үндэслэн сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохоор заажээ.

1.26 Сургуулиуд дээрх аргачлалыг мөрдөж ажиллаагүй, БСШУЯ боловсронгуй болгох ажлыг хийгээгүйгээс сургалтын төлбөрийг сургууль бүр өөр өөрийн аргачлалаар тогтоож, орлого зардал тэнцүү байх зарчим алдагдаж, 2015-2016 оны хичээлийн жилд аудитад хамрагдсан 9 сургууль 34.6 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй, 5 сургууль 10.7 тэрбум төгрөгийн дутагдалтай ажилласан байна. *(Судалгааг хавсралт А, Б-д үзүүлэв)*

*[11]Дээд боловсролын сургалтын байгууллага болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад төрөөс үзүүлэх буцалтгүй тусламж, зээл, тэтгэлгийн хэмжээг Засгийн газар жил бүр тогтооно*

*[12] сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу Удирдах Зөвлөл тогтоох чиг үүрэгтэй.*

Сургуулиуд үндсэндээ сургалтын төлбөрийн хэмжээг урьд оны санхүүгийн хүрсэн түвшин, сургуулийн Удирдах зөвлөлөөр баталсан шинэ хичээлийн жилийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөсөн зардал, цалингийн өсөлт, инфляцийн түвшин [13] болон оюутны зөвлөлийн саналыг харгалзан нэмэгдүүлж, Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэж байна. Тухайлбал,

- *ШУТИС-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааны журамд 1 кредитийн зардлыг хэрхэн тооцох талаар тусгаагүйгээс удирдлагатай холбоотой шууд бус зардлыг 1 кредитийн зардалд хэрхэн хуваарилах нь тодорхойгүй, сургалтын төлбөрийн орлогоос хөрөнгө оруулалт, сургалтын бааз бэхжүүлэх зардалд хөрөнгөө хэрхэн зарцуулах үндэслэл, тэдгээрийн тооцооллыг нарийвчлан заагаагүй байна. Бүрэлдэхүүн сургуулиуд өөрийн сургуулийн сургалттай холбоотой нийт зардлын дүнгээс улсын төсвөөс санхүүжиж буй урсгал зардал, сургууль хоорондын орлогыг хасч тухайн сургуулийн дундаж оюутны тоонд хуваах замаар сургалтын төлбөрийн хэмжээг тогтоож байна. Харин зардлыг оюутны тоонд тулгуурлан төлөвлөхгүйгээр, өмнөх жилийн зардлын гүйцэтгэл, шаардлагатай хөрөнгө оруулалт, цалингийн өсөлт зэрэгт тулгуурлан төлөвлөдөг байна.*
- *МУИС сургалтын төлбөрийг тогтоохдоо бүрэлдэхүүн сургууль бүрийн өмнөх онд гарсан шууд болон шууд бус зардал, МУИС-ийн захиргаа, нийтлэг үйлчилгээний зардлын нийлбэр "Си Си" програмаас гарах оюутны судалсан багц цаг (дунджаар 30 багц цаг судлахаар тооцдог) болон оюутны тоонд хувааж тооцсон байна.*
- *МУБИС нэг кредитийн өртгийг зардалд үндэслэн тооцсон боловч инфляцийн нөлөөллийг хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна.*
- *ХААИС өмнөх хичээлийн жилийн нэг кредитийн төлбөрийг суурь болгон тодорхой хувиар өсгөх замаар буюу жишээлбэл, 2014-2015 оны төсөвт хичээлийн 2 дугаар байрыг барьж, ашиглалтад оруулахтай холбогдуулан БУА-ын санхүүжилтэд 1,000.0 сая, 2015-2016 оны төсөвт хичээлийн 2 дугаар байрны санхүүжилтэд 400.0 сая төгрөг, инфляцийн түвшинтэй уялдуулан багш ажилчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэх шаардлага зэргийг үндэслэл болгон сургалтын төлбөрөө нэмэгдүүлсэн байна.*

1.28 Судалгааны дүнгээс үзэхэд сургуулиудын сургалтын төлбөр 2013-2014 оны хичээлийн жилтэй харьцуулахад 2014-2015 онд дунджаар бакалаврынх 17.3 хувь, магистрынх 15.5 хувь, докторынх 15.4 хувь, 2015-2016 оны хичээлийн жилд бакалаврынх 19.9 хувь, магистрынх 19.2 хувь, докторынх 15.7 хувиар тус тус өссөн нь жилийн эцсийн инфляцийн түвшингээс 2014 онд 3.6 хувиар, 2015 онд 7.6 хувиар илүү байна. (*Дэлгэрэнгүйг хавсралт Е-д үзүүлэв*)

1.29 Дээрх өсөлт ихэнхдээ инфляцийн түвшингээс шалтгаалсан гэж байгаа ч сургууль бүрийн төлбөр харилцан адилгүй нэмэгджээ. Тухайлбал,

- *ШУТИС сургалтын төлбөрөө 2014-2015 оны хичээлийн жилд өмнөх оны түвшингээс 13.3 хувь, 2015-2016 оны хичээлийн жилд 1 дүгээр курс 25 хувь, бусад курс 15 хувиар тус тус нэмэгдүүлсэн нь инфляцийн түвшингээс 2.8-11.7 хувиар өндөр;.*
- *ХААИС сургалтын төлбөрөө 2013-2014 онд 13.5 хувь, 2014 онд 15.0 хувь, 2015 онд 20.0 хувиар тус тус нэмэгдүүлсэн нь инфляцийн түвшингээс 2.5-9.0 хувиар илүү;*
- *МУБИС-ын сургалтын төлбөр 2013-2014 онд 13.5 хувь, 2014-2015 онд 15.0 хувь, 2015-2016 онд 15-20 хувиар нэмэгдсэн нь гол үндэслэл гэгдэх инфляцийн түвшингээс тус тус өндөр байна.*

1.30 ХСИС бакалаврын сургалтыг кредит цагтай холбоогүйгээр байгууллагын ерөнхий зардлаар төсөвлөж, үнэ төлбөргүй явуулдаг ч ямар нэг шалтгаанаар (өөрийн хүсэлтээр, буруутай үйлдэл, сахилгын шийтгэл гэх мэт) сургуулиа төгсөлгүй орхисон сонсогчдоос суралцах хугацаанд төрөөс санхүүжүүлсэн зардлыг нөхөн төлүүлэх асуудал зохицуулагдаагүй орхигдсон байна.

1.31 Боловсролын тухай хуулийн 40.4.5[14]-д заасны дагуу БХИС төрийн зардлаар сургалт явуулах ёстой боловч Сангийн яамнаас орлого бүрдүүлэх төлөвлөгөө өгч, тус сургуулийн 1-3 дугаар дамжаанд сургалтын төлбөр төлж, харин 4 дамжаанд Зэвсэгт хүчний жанжин штабаас захиалсан орон тооны дагуу сонгон шалгаруулалтаар Цэргийн нэгдсэн сургуульд элсүүлж, сургалтын төлбөрөөс чөлөөлж байгаа нь хуулийн дээрх заалттай нийцэхгүй байна.

1.32 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй салбар, бүрэлдэхүүн сургуулиудын хувьд төв сургуулиас тогтоосон сургалтын төлбөрийн жишгийг баримтлан ажиллаж байна. Бүс нутгийн хөгжил, сургалт, мэдээллийн орчин зэргийг харгалзан сургалтын төлбөрийг байршлаас хамааруулан төв сургуулиас бууруулан шатлан тогтоох нь салбар сургуулиудын хөгжлийг

[13] *Эх сурвалж www.1212.mn сайтад мэдээлснээр 2013 оны жилийн эцэст инфляцийн түвшин 14 хувь, 2014 онд 12.5 хувь, 2015 онд 11.0 хувь*
[14] *Цэрэг, цагдаагийн дээд боловсрол эзэмшүүлэхтэй холбоотой зардлыг төр хариуцна.*

вортой байлгах, хөдөөнөөс хот руу тэмүүлэх төвлөрлийг сааруулах зэрэг нөлөө үзүүлж болохоор байна.

1.33 Түүнчлэн сүүлийн жилүүдэд сургалтын төлбөрийг дамжаа, ангиудад тогтоосон ямар нэг шалгуургүйгээр харилцан адилгүй нэмэгдүүлэх байдал ажиглагдаж байна. Тухайлбал,

- *ХСИС магистр, докторын сургалтын төлбөрийг бодит зардлаас доогуур тогтоосон.*
- *АШУҮИС докторант, магистрантын сургалтын төлбөрийг жил бүр 300.0-500.0 мянган төгрөгөөр тогтмол өсгөн тогтоож байгаа ч гадаад оюутны сургалтын төлбөрийг нэмээгүй байна.*
- *ХИС-ийн бакалаврын сургалтын төлбөр өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 2014-2015 онд 3.2 хувиар буурч, 2015-2016 онд 46.3 хувиар нэмэгдсэн, харин магистрын төлбөр 2014-2015 онд 4.3 хувиар буурч, 2015-2016 онд 71.1 хувиар нэмэгдсэн. 2015-2016 оны хичээлийн жилд бакалаврын сургалтын төлбөр 1-р дамжаанд 12.5 хувь, 2-р дамжаанд 33.3 хувь, 3-р дамжаанд 18.5 хувь, 4-р дамжаанд 15.6 хувиар тус тус нэмэгдсэн.*

***Зарим их, дээд сургуулиуд сургалтын төлбөрийг жил дараалан нэмэгдүүлж, зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийн хуримтлал үүсч, хугацаатай хадгаламжаар байршуулж байна***

1.34 Сургалтын төлбөрийн хэмжээг тогтвортой байлгахад санхүүгийн нөөцийг арвилан хэмнэлттэй, үр ашигтайгаар зохистой удирдах, бодлого шийдвэрийн эрх зүйн хэм хэмжээг сайжруулах шаардлагатай байгаа нь ажиглагдаж байна.

1.35 Сургуулиудын үйл ажиллагааны орлого, зардлын зөрүүгээр илэрхийлэгдэж буй үр дүнгийн үзүүлэлт харилцан адилгүй байна. Тухайлбал,

*Дүрслэл 2. Зарим сургуулиудын орлого, зардлын гүйцэтгэлийн судалгаа (сая төгрөг)*




1.36 Хичээлийн жилийн эцсээрх 1.0 тэрбум төгрөгөөс дээш мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй 4 томоохон их сургуулийн жишгээр харуулбал,

1.37 Томоохон зарим сургуулиудын хувьд 2013-2014 оны хичээлийн жилийн эцэст буюу 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 44.5 тэрбум төгрөг байсан бол 2014-2015 оны хичээлийн жилд 67.8 тэрбум болж, 52.1 хувиар нэмэгдсэний дотор хадгаламж 10.9 тэрбум төгрөгөөр буюу 4.7 дахин нэмэгдэж, нийт мөнгөн

*Хүснэгт 3. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл хичээлийн жилийн эцэст (сая төгрөг)*

| Сургуулиуд | | 2013-2014 | 2014-2015 |
|---|---|---|---|
| ШУТИС | Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл | 15,828.8 | 17,857.0 |
| | Үүнээс, харилцах дансны хүүгийн орлого | 238.7 | 296.7 |
| МУБИС | Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл | 11,863.5 | 8,595.6 |
| | Үүнээс, хадгаламж | 2,946.3 | 2,081.3 |
| МУИС | Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл | 9,355.7 | 28,966.9 |
| | Үүнээс, хадгаламж | | 11,803.6 |
| АШУҮИС | Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл | 7,403.0 | 12,189.0 |

өнгийн үлдэгдлийн 20.5 хувийг эзэлж байна.

1.38 Зарим сургуулиуд сургалтын төлбөрийн орлогоос арилжааны банкинд ихээхэн хэмжээний хадгаламжийг нэгээс дээш жилийн хугацаатайгаар байршуулан нэмэлт орлогын эх үүсвэр болгон ашиглаж үйл ажиллагаагаа явуулахад тодорхой хэмжээний дэмжлэг болж чадсан ч хадгаламжийн үлдэгдлийг дараа жилийн төсөвт буюу сургалтын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх мөнгөн эх үүсвэрт оруулан тооцохгүй байгаа нь сургалтын төлбөр нэмэгдэх, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах зэрэг эрсдэлүүдийг үүсгэхээр байна. Тухайлбал,

- *АШУҮИС ХААН банкинд 1,000.0 сая, Төрийн банкинд 500.0 сая төгрөг нийт 1,500.0 сая төгрөгийг 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай, 17.2 хувийн хүүтэй;*
- *МУИС 2015 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар 27,973.8 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байгаагаас 11,803.6 сая төгрөг буюу 40.7 хувийг арилжааны 4 банкинд хугацаатай;*
- *МУБИС 2014 оны 5 дугаар сарын 27-ноос 1,002.3 сая төгрөгийг 1 жилийн, 2014 оны 8 дугаар сарын 11-ний өдрөөс 2,081.3 сая төгрөгийг 1 жилийн, 2015 оны 10 дугаар сарын 27-ноос 500.0 сая төгрөгийг 180 хоногийн хугацаатайгаар тус тус байршуулсан байна.*

1.39 Дээрх нөхцөл байдал нь тухайн жилийн төсөв, сургалтын төлбөрийн хэмжээг тогтоох тооцоололтой холбоотой бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-д “*Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх*” гэж заасан төсвийн зарчмыг хэрэгжүүлэх явцтай нийцэхгүй байна. Цаашид хадгаламжийг зарцуулахаар төлөвлөсөн хугацаандаа чөлөөлөгдөх боломжтойгоор байршуулж байх шаардлагатай байна.

1.40 Мөн сургуулиудын хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанаас хамаарч санхүүгийн тайлангаар жилийн эцэст ихээхэн хэмжээний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарч байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.8[15]-д заасны дагуу Сангийн яамнаас төсвийн төлөвлөлт, бүртгэлийг хэрхэн хийх талаар аргачлал баталж, мөрдүүлэх ажил хийгдээгүйгээс шалтгаалжээ.

1.41 Иймд санхүүгийн эх үүсвэр, түүний зарцуулалт, өртөг зардлын тооцоолол хийх, оюутны сургалтын төлбөрийг тогтоох, үйл ажиллагааны бүртгэлийг хэрхэн хийх талаарх арга аргачлалыг сайжруулан боловсруулж мөрдөх шаардлагатай болжээ.

1.42 Их, дээд сургуулийн сургалтын төлбөрийн хэрэглээний сагсанд эзлэх хувийн жин өндөр байдгаас эдийн засгийн хувьд инфляци өсөх шалтгаануудын нэг болж байна. Нийт их, дээд сургуульд суралцагчдын 90.0 хувь нь хувийн зардлаар суралцдаг тул төлбөрийн өсөлт нь оюутнууд, тэдний өрхийн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна.

1.43 Сургалтын төлбөрийн өсөлт 2013-2015 онд хэрэглээний үнийн индекс[16]-т хэрхэн нөлөөлсөн талаар дурдвал,

- *Хэрэглээний үнийн индекс 2013 оны эцэст өмнөх оныхоос 12.5 хувиар өссөний дотор боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ дүнгээрээ 27.2 хувь өссөн нь ТӨИДС-ийн 1-р дамжааны сургалтын жилийн төлбөр 2013 оны 12 сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 33.2 хувиар нэмэгдсэнтэй;*
- *2014 оны эцэст хэрэглээний үнийн индекс өмнөх оныхоос 11 хувь өссөний дотор боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ дүнгээрээ 16.8 хувь өссөн нь ТӨИДС-ийн 1-р дамжааны сургалтын жилийн төлбөр 2014 оны 12 сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 7.6 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.*
- *ТӨИДС-ийн 1-р дамжааны сургалтын жилийн төлбөр 2015 оны 9 сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхтэй болон өмнөх оны эцэстэй харьцуулахад 32.5 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2015 оны 9 дүгээр сард оны эхнээс 2.6 хувиар өсөхөд 1.3 нэгж (52.2 хувь) нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.*

1.44 ТӨИДС-иудын мөнгөн орлого, зардлын гүйцэтгэл, харилцах дансны чөлөөт үлдэгдэл зэргээс үзэхэд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй явуулах санхүү, хөрөнгийн зохистой хэмжээний нөөцөөр хангагддаг гэж үзэхээр байна. Нэгэнт бий болсон дээрх мөнгөн хөрөнгийн хуримтлалыг тухайн сургуулийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах замаар хөрөнгийн эх үүсвэрт ашиглаж, зардлын төлөвлөлтийн эрх зүйн орчинг боловсронгуй болгон цаашид ийм нөхцөл байдал үүсгэхгүй байх шаардлагатай байна.

---

[15] *Салбарын үйл ажиллагааны онцлогоос хамаарч төсвийн хэрэгжилтийн хугацаа нь төсвийн жилээс зөрүүтэй бол төсвийн төлөвлөлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу зохицуулна.*
[16] *Эх сурвалж: www.1212.mn*

*ал асуулгын дүн:* *Нийт 1,157 багш, ажилтан, 4,819 оюутнаас авсан санал асуулгын дүнгээр сургалтын төлбөрийн хэмжээг бодитой тогтоож байгаа эсэх, сургалтын төлбөр чанартайгаа нийцэж байгаа эсэхэд ихэнх оюутнууд "үгүй" гэж хариулсан нь сургалтын төлбөрийг илүү бодитой тогтоох, төлбөртэй нийцсэн чанарыг бий болгох, төлбөр тогтоолтыг нээлттэй ил тод болгох зохистой арга хэмжээ авч ажиллах шаардлагатайг илтгэж байна. (Дэлгэрэнгүйг хавсралт Д-гээс үзнэ үү)*

***Зарим сургууль суралцагчдаас хуульд заагдаагүй төлбөр, хураамж авч байна***

1.45 СУИС-ийн Удирдах зөвлөлийн 2015 оны 3 дугаар тогтоолоор 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн сургалтын төлбөрөөс гадна бакалаврын сургалтын суурь хураамжийг 80.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

1.46 Мөн МУИС-ийн захирлын 2011 оны 304 дүгээр тушаалаар "МУИС-ийн бакалаврын сургалтын журам"-ыг батлахдаа 18.1-д "Сургалтын төлбөр нь судлах хичээлийн багц цагийн төлбөр, улирлын суурь хураамжийн нийлбэрээр тодорхойлогдоно" гэж заасан байна. Гэтэл суурь хураамжийн тооцоололд оруулж буй тодорхой нэр төрлийн зардлууд нь улсын төсөв болон сургалтын багц цагийн төлбөрөөр санхүүжиж байгаа тул суралцагчдаас авч буй төлбөр, мөн хураамжийг тооцох зардлыг давхардуулж байгааг харуулж байна.

1.47 Дээрх журам нь Боловсролын тухай хуулийн 36.11.4-ийн "сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох" 40.7-гийн "Суралцагчаас хуульд заагаагүй төлбөр хураамж авахыг хориглох" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

1.48 Суурь хураамжид 2011-2014 оны хичээлийн жилүүдэд бакалаврын түвшний суралцагчдаас 200.0 мянган төгрөг, магистр, докторт 300.0 мянган төгрөг төлүүлж байсан бол 2015-2016 оны хичээлийн жилд бакалаврын сургалтад элсэгчдээс 224.0 мянга, магистр, докторын элсэгчдээс 336.0 мянган төгрөг байхаар тогтоон, сургалтын төлбөр дээр нэмж төлүүлжээ. 2011-2015 онд нийт 25.4 тэрбум төгрөгийн суурь хураамжийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд 2013-2015 онд 63,721 оюутнаас 14.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

*Санал асуулгын дүн:* *Сургуулиудын 1,158 багш, ажилтан, 4,709 оюутнаас авсан "Сургалтын төлбөрөөс гадуур хууль бус төлбөр, хураамж авдаг уу?" гэсэн асуулгад 24.1 хувь нь авдаг, 23.5 хувь мэдэхгүй гэж хариулжээ. Сургалтын төлбөрөөс гадуур ямар төлбөр, хураамжийг түлхүү авдаг талаар санал асуулгын дүнгээр суралцагчид ихэвчлэн дараах тайлбарыг хийсэн байна. Үүнд:*

- *Хичээлийн дундуур илүү сонгосон кредит, хичээл сонголтоос хоцорсны төлбөр авдаг;*
- *Смарт карт, тасалбар, спортын хувцас шахдаг;*
- *Гэрээний төлбөр, кабинет тохижуулах төлбөрийг оюутнуудаас авдаг;*
- *Багш нар ном зарж дүн гаргадаг гэх мэтээр хариулж байна.*

***Төсвийн бүрэлдэхүүнд үндэслэлгүй зардал батлуулсан байна***

1.49 Зарим сургуулиуд зардлын төсвийг удирдах зөвлөлөөр батлуулахдаа үндэслэлгүйгээр зардлын дүнг нэмэгдүүлэн эх үүсвэр батлуулж байгаа нь сургалтын төлбөрийн өсөлтийг бий болгож байна. Тухайлбал,

- *ШУТИС 2014-2015 оны хичээлийн жилийн төсвийг 2014 оны 4 дүгээр сард удирдах зөвлөлөөр барилга байгууламжийн хөрөнгө оруулалтад 10.6 тэрбум төгрөгийн зардлыг оруулан батлуулж, тухайн эх үүсвэрийг Удирдах зөвлөлийн 2014 оны 9 дүгээр тогтоолоор 10.2 тэрбум төгрөгөөр бууруулсан. 2015-2016 оны хичээлийн жилийн төсөвт 2015 оны 2 дугаар сард дахин 7.7 тэрбум төгрөг батлуулснаа 2015 оны 12 дугаар сарын 15 дугаар тогтоолоор 7.4 тэрбум төгрөгөөр хасах тодотгол хийлгэсэн байна.*
- *ХААИС 2013-2014 оны хичээлийн жилийн төсвийг Удирдах зөвлөлөөр батлуулахдаа банкны зээл төлөх нэрээр 2.5 тэрбум төгрөгийг зардал болгон батлуулсан;*
- *МУИС 2014 оны төсөвтөө номын сангийн барилга барих 5.3 тэрбум төгрөгийн зардлыг батлуулсан боловч ашиглаагүй.Мөн хэвлэл, хичээл практик, оюутны үйл ажиллагааг дэмжих, мэргэжлийн олимпиад, гадаад багш ажиллуулах, багш, ажилтны үйл ажиллагааг дэмжих зэрэг зардлыг жил бүр 25.2-аас 230.8 хувиар үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн төлөвлөсөн.*

***...галтын төлбөр, татаас, бусад орлогыг зарцуулахдаа үр ашиггүй зардал гаргаж, арвилан хэмнэлтийн зарчмыг баримтлахгүй байна***

1.50 Сургуулиуд хөрөнгө, санхүүгийн нөөцийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан тохиолдол цөөнгүй гарч байна. Зарим томоохон жишээг дурдвал,

***ШУТИС:***

- *2013 онд бүрэлдэхүүн сургуулиуд багш, ажилтнуудын орон сууцны барилгын зоорийн давхрын 974.6м$^2$ талбайг 1,407.5 сая төгрөгөөр худалдан авсан болович зарим хэсгийн талбайг ашиглаж эхлээгүй байна.*
- *ТӨХ-ноос авсан зөвшөөрлийн дагуу 2014 онд ректорын албан хэрэгцээнд 154.0 сая төгрөгөөр Ланд крузер 200 автомашин худалдан авсан;*
- *ШУТИС-ийн ректорын 2012 оны А/76, А/159 дүгээр тушаал, 2013 оны А/77 дугаар тушаалын дагуу нано боловсруулалт бүхий даавуу үйлдвэрлэх туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг (БСШУЯ-наас 155.0 сая төгрөг, БИАС-иас 298.7 сая төгрөг, ЭХИС-иас 199.2 сая төгрөг, Эрдэм шинжилгээний газраас 109.3 сая төгрөг тус тус санхүүжүүлж) буюу 762.2 сая төгрөгөөр худалдан авсан болович Удирдах зөвлөлийн 2013 оны 9 дүгээр тогтоолын дагуу "Эрдэнэт хивс" ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулж, 2014 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр шилжүүлсэн ба Эрдэнэт хивс ХХК-тай байгуулсан гэрээний заалтууд 2015 оны 12 дугаар сарын байдлаар хэрэгжээгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, 497.8 сая төгрөгийг ЭХИС, БИАС хоорондын, 109.3 сая төгрөгийг Эрдэм шинжилгээний газраас авах авлагаар бүртгэсэн ба хэрхэн барагдуулах нь тодорхойгүй байна. Түүнчлэн дээрх тоног төхөөрөмжийг 2013 оны 1 дүгээр сараас 1 жил орчмын хугацаанд ашиглаагүй, агуулахад хадгалуулж, түрээсийн төлбөрт 5.3 сая төгрөгийг шилжүүлж үргүй зардал гаргасан;*
- *БСШУЯ нь ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн 207.6м$^2$ талбайг түрээслэх гэрээг байгуулж, түрээсийн төлбөрт 18.7 сая төгрөгийг шилжүүлсэн болович уг талбайг түрээслэж ашиглаагүй бөгөөд Геологи, уул уурхайн сургуулиар дамжуулан БСШУЯ-ны нэр бүхий 4 гэрээт ажилтны үндсэн цалин, хоол унаа, НДШ, ХХОАТ зэрэгт бүгд 18.4 сая төгрөгийг олгосон зөрчилд албан шаардлага бичив.*

***МУБИС:***

- *БСШУЯ-наас зөвшөөрөл авч 2014 онд ТӨХ-нд хүргүүлэн МУБИС-ийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр Lexus 570 авто машиныг Сувдан хур ХХК-иас 172.0 сая төгрөгөөр худалдан авсан болович Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолын 4 дэх хэсэгт заасан "хот доторх ажил үйлчилгээнд том оврын туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэхийг хориглосон заалтыг зөрчсөн тул ТӨХ хураан авсан. МУБИС-ийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд уг хөрөнгө бүртгэлгүй, Сувдан хур ХХК-ий авлагаар бүртгэснээр өнөөг хүртэл залруулаагүй байна;*
- *Сүүлийн 3 жилийн МУБИС-ийн санхүүгийн тайланд "Их наяд аудит" ХХК гэрээний үндсэн дээр (10-20 сая төгрөгөөр) баталгаажуулах аудит хийж, 2014 оны санхүүгийн тайланд авлагыг буруу тайлагнасан, олон жил дамжсан, дахин аудит хийх шаардлагатай гэсэн дүгнэлтийг өгсний дагуу "Конфиденс аудит" ХХК гэрээ байгуулан аудит хийж дүгнэлтэд Их наяд аудит ХХК-ий ажилтнууд гарын үсэг зурж ирүүлсэн нь өмнөх аудитын дүгнэлтийг хуулбарласан байх бөгөөд Аудитын тухай хуулиар аливаа эрсдэлийг санхүүгийн тайланг баталгаажуулсан аудитын компани хариуцах ёстой болович 70.0 сая төгрөгийн үйлчилгээний хөлс авсны үр дүн харагдахгүй байна.*

***ХААИС:***

- *Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолын 5, 6 дах заалтыг зөрчиж, ТӨХ-ны шийдвэргүйгээр Land cruiser 200 автомашиныг сургуулийн хөрөнгөөр худалдан авсныг 2015 оны 5 дугаар сарын 7-нд ТӨХ-ноос хураан авч Засгийн газрын автобаазад хүлээлгэн өгчээ.*

***Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагнал хангалтгүй, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд тавигдах шат шатны хяналт хангалтгүй байна***

1.51 Сургуулиудын санхүү, аж ахуйн үйл ажиллагааны хяналт сул байгаагаас бараа материал, хөрөнгийн тайлагнал бодитой бус, хөрөнгө үрэгдэх, эзэнгүйдэх эрсдэл оршсоор байна.

1.52 НББТХ, ТБОНӨТХ-ийн холбогдох заалтуудыг зөрчиж анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил, гүйлгээ хийж бүртгэж, тайлагнасан, хөрөнгө олгосон, томилолтын урьдчилгааг суутган тооцоогүй, цалин хөлс, хоол, унааны хөнгөлөлт, шагнал, ажлын хөлс, томилолтын зардлыг илүү, дутуу, давхардуулан олгосон, орлогоос татвар суутган тооцохгүй байх, тайлан тооцоо хийхгүй орхигдуулах зэрэг зөрчил илэрсэнд улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 105.2 сая төгрөгийн 24 төлбөрийн акт тогтоож, 9,595.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 9,595.9 сая төгрөгийг алдаа, зөрчлийг залруулах 25, холбогдох ажилтанд хариуцлага тооцох 15 албан шаардлага өглөө. *(Дэлгэрэнгүйг хавсралт Ж, 3-гээс үзнэ үү)*

***Үндсэн бус үйл ажиллагааны орлогыг төлөвлөх, зарцуулах, тайлагнах үйл ажиллагаанд тавигдах хяналт сул байна***

1.53 Сургуулиудын сүүлийн 2 хичээлийн жилийн үндсэн бус үйл ажиллагааны орлого төлөвлөснөөс 34.6 хүртэл хувиар буюу 2013-2014 онд 9,522.4 сая, 2014-2015 онд 10,815.6 сая

өгөөр давж биелсэн нь нийт орлогод дунджаар 19.8 хувийг эзэлж байна. (*Дэлгэрэнгүйг хавсралт А-гаас үзнэ үү*)

1.54 Зарим сургууль үндсэн бус үйл ажиллагааны орлогыг төсөвлөхдөө өмнөх онуудын гүйцэтгэлтэй уялдуулахгүй байх, нөөцийг бодитой тооцдогггүй, жилийн дундуур орлого, зардлын гүйцэтгэлийг хянаж тодотгол хийдэггүйгээс батлагдсан төсөвтэй харьцуулахад гүйцэтгэл ихээхэн зөрүүтэй байна.

*Судалгаа 2. Үндсэн бус үйл ажиллагааны орлого (сая төгрөг)*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2013-2014 | | 2014-2015 | |
|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| Эрдэм шинжилгээ, судалгааны ажил | 4,655 | 5,438 | 4,961 | 4,199 |
| Хандив, тусламж | 245 | 2,783 | 712 | 7,173 |
| Зээл | | | 200 | 500 |
| Бусад | 22,425 | 28,626 | 25,638 | 30,455 |
| ДҮН | 27,324 | 36,847 | 31,511 | 42,327 |

***Түрээсийн орлогоос төсөвт төлөх хэсгийг хугацаанд нь шилжүүлээгүй байна***

1.55 ТБОНӨТХ-ийн 26[17], 28[18] дугаар зүйл, ТӨХ-ны 2007 оны 42 дугаар тогтоолын дагуу 1 м.кв ашигтай талбайн түрээсийн төлбөрийн доод хэмжээ 5.0 мянган төгрөг байна. АШУҮИС нэгж талбайг 12.0 мянган төгрөгөөр, ХААИС 10.0 мянган төгрөгөөр, МУБИС 5.8-25.0 мянган төгрөгөөр тус тус түрээслүүлжээ.

1.56 Дээрх байршилд түрээсийн нэгж талбайн зах зээлийн үнэ 35.0-45.0 мянган төгрөг байгаа тул төрийн өмчийн нэгж талбайн түрээслэх үнийг зах зээлийн ханшид ойртуулснаар нэмэлт орлого олох боломж байна.

1.57 ТӨХ-ний 2007 оны 42 дугаар тогтоолын 2в-д "*төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан балансад бүртгэлтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлснээс олсон орлогын 20 хувийг ТӨХ-ны төрийн сангийн дансанд сар бүр төвлөрүүлж, улирал, жилийн эцэст тус хороотой тооцоо нийлж акт үйлдэж байх*" гэж заасан боловч зарим сургууль төвлөрүүлэхгүй байх тохиолдол гарч байна. Жишээлбэл,

- *МУБИС 2013 онд түрээсийн орлогоос 14.3 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 1.8 сая төгрөгийг дутуу;*
- *ХААИС 2015 оны эхний 3 улирлын түрээсийн орлогын 20 хувь болох 3.8 сая төгрөгийг хугацаанд нь төвлөрүүлээгүй байна.*

1.58 Боловсролын тухай хуулийн 39.3-т "*Боловсролын сургалтын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, багш, ажилтан, суралцагчийн нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж болох бөгөөд түүнээс олсон орлогоо энэ хуульд заасан зориулалтын дагуу захиран зарцуулах эрхийг боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч эдэлнэ*" гэж заасан боловч үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг тусад нь бүртгэж, үр дүнг тооцдоггүйгээс хэрхэн үйл ажиллагаа, сургалтын орчинд үр нөлөө үзүүлж буйг нотлох нотолгоо алга байна.

1.59 Гэгээрлийн сайд (хуучин нэрээр)-ын 1999 оны 107 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу үндсэн бус үйл ажиллагааны зардлыг үндсэн бус үйл ажиллагааны орлогоор нөхөх ёстой боловч зарим сургуулиуд туслах үйл ажиллагааныхаа зардлыг сургалтын төлбөрийн орлогоос нөхдөг байна.

[17] *Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана.*
[18] *28 дугаар зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх 28.1-д "... Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх" журмыг...Засгийн газар тогтооно; 28.2-т Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ; 28.3-т Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана.*

***Төрөөс баримтлах бодлого, сургуулиудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлэхүйц хэмжээний хугацаа өнгөрөөгүй байна***

2.1 Боловсролын салбарын амжилт, бүтээмж нь бага зардлаар ашиг олохдоо бус мэдлэг, чадвартай багш, судлаачдаар багаа бүрдүүлж чадсан эсэх, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх байдал, сургалт-судалгаа-үйлвэрлэлийн амжилттай хослол, үр дүнгээр тодорхойлогддог.

2.2 УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын салбарыг 4 үндсэн чиглэлийн дагуу хөгжүүлэхээр төлөвлөн их, дээд боловсролын байгууллагууд чиг үүргийнхээ хүрээнд тодорхой ажлуудыг гүйцэтгэсэн байхаар зохицуулсан байна. Үүнд:

- *Сурагч, оюутан, багш, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, тогтолцооны шинэчлэлт хийх ажлын хүрээнд “дээд болон мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн даяарчлагдсан зах зээлд амжилттай өрсөлдөх, бие даан ажлын байр бий болгох, улс үндэстний болон орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, үндэсний инновацийн чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах чадамж эзэмших үе хэмжээг хөгжүүлнэ”*
- *Боловсролын чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах, насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд “мэдээллийн технологийг сургалтын орчинд өргөнөөр ашиглаж, сурах бичиг, видео хичээл, танин мэдэхүйн цахим хуудас нээж ажиллуулах”, “чанаргүй их, дээд сургуулиудыг цөөлж сургалт, судалгаа, үйлдвэрлэл хосолсон, зах зээлд эрэлт хэрэгцээтэй боловсон хүчин бэлтгэдэг сургалтын системд шилжүүлж, дэргэдээ эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, туршилтын инкубатор байгуулан, өндөр технологийн компанийг бойжуулж, бүтээлээ зах зээлд нэвтрүүлэхийг төрөөс дэмжих”, “хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг зориулалтын сурах бичиг, тоног төхөөрөмжөөр хангаж, коллеж, их, дээд сургуульд элсэн суралцах боломжийг дээшлүүлэх”, “бүх шатны боловсролын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн, цагийг нэмэгдүүлэх, секцийн цагийн хөлсийг олгох, идэвхтэн дасгалжуулагчтай байхыг дэмжих”*
- *Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлэх ажлын хүрээнд “судалгаа, шинжилгээний ажлыг их, дээд сургууль болон бодлогын институт дээр төвлөрүүлж, Шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн санхүүжилтийг энэ зорилготой уялдуулах”*
- *Боловсрол, шинжлэх ухааны салбарын менежмент, эдийн засаг, санхүү хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэх ажлын хүрээнд “Боловсрол, шинжлэх ухааны байгууллагын удирдлага, зохион байгуулалт, менежментийг олон нийтийн оролцоонд суурилсан, ардчилсан, хараат бус, нээлттэй зарчимд шилжүүлэх”, “сургалтын технологийн хөгжил, санал санаачлагыг дэмжин хөгжүүлэх зорилго бүхий боловсролыг дэмжих үндэсний сан бий болгох”*

2.3 Засгийн газрын 2010 оны 31 дүгээр тогтоолоор боловсролын салбарын тулгамдсан асуудлыг иж бүрнээр нь цогц байдлаар шийдвэрлэх зорилгоор “Боловсрол” үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд 1 дүгээр шат 2015 онд хэрэгжиж дуусах, 2 дугаар шат 2021 он хүртэл үргэлжлэхээр байна.

2.4 Аудитад хамрагдсан хугацаанд “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг (2014-2024 он) УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, дээд боловсролын хөгжилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, дээд боловсролын байгууллагад академик эрх чөлөө олгох, иннновацийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулах, олон улсын жишигт нийцүүлэн төрөл бүрийн хэв шинжтэйгээр хөгжүүлэх зэрэг асуудлыг нэмж оруулсан байна. Тухайлбал,

- *1.3.1-д Боловсролыг хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, иргэний оролцоог хангах;*
- *3.1-д Боловсролын үйл хэргийг удирдахад төрийн болон нутгийн захиргааны, иргэний нийгмийн байгууллага, гэр бүл, нийгмийн бүх салбарын оролцоонд суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлнэ;*
- *3.6-д дээд болон мэргэжлийн боловсрол нь хөдөлмөрийн даяарчлагдсан зах зээлд амжилттай өрсөлдөх, бие даан ажлын байр бий болгох, улс үндэстний болон орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг үндэсний онцлогт тулгуурлан шийдвэрлэх, үндэсний инновацийн чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах чадамж эзэмших үе хэмээн хөгжүүлнэ;*
- *3.15-д ...боловсролын байгууллагын академик эрх чөлөөг хангана;*

*3.16-д ...дээд боловсролын байгууллагын судалгааны үйл ажиллагааг дэмжинэ;*

*3.17-д дээд...боловсролыг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулна гэх мэт*

2.5 БШУС-ын 2014 оны А/370 дугаар тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалавр, магистр, докторын мэргэжлийн чиглэл (хөтөлбөр), индексийг 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөхөөр шинэчлэн баталсан байна.

2.6 Дээрх тушаал хугацааны хувьд 9 дүгээр сарын 12-нд батлагдсанаас их, дээд сургуулиудад сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөө боловсруулж, Эрдмийн зөвлөлөөр батлуулан хичээлийн жилийн эхнээс мөрдөх нөхцөл боломжийг олгоогүй ч, сургуулиудын хөтөлбөрийн хороо сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хугацааны алдагдалтайгаар батлуулж, 2014-2015 оны хичээлийн жилээс сургалтын үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн байна.

2.7 Зарим их, дээд сургуулиуд сургалтын, удирдлага мэдээллийн цогц системийг нэвтрүүлснээр суралцагч өөрөө сурах хугацаа, багш, судлах хичээлээ сонгодог болсон нь эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс энэхүү системийн тусламжтайгаар хяналт тавих боломжийг бий болгожээ.

2.8 Их, дээд сургууль, сургалтын хөтөлбөр олон улсын дээд боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлэгдэж байгаагаас харахад ТӨИДС-иудын явуулж буй сургалт олон улсад хүлээн зөвшөөрөгдөх эхлэл тавигджээ. Тухайлбал,

- *АШУҮИС-ийн Эрүүл мэндийн технологийн сургууль APACC [19] -ийн магадлан итгэмжлэл, Анагаах ухааны сургуулийн "Ерөнхий мэргэжлийн анагаах ухаан" бакалаврын хөтөлбөр AMEWPR[20] –ийн магадлан итгэмжлэл*
- *ШУТИС-ийн ЭХИС-ийн "Цахилгаан хангамж" мэргэжлээр бакалавр, магистр зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр Герман улсын ASIIN[21], Европын холбооны EUR-ACE[22]*
- *МУИС-ийн Эдийн засгийн, ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн, ХААИС –ийн Эдийн засаг бизнесийн сургуулиуд АНУ-ын ACBSP[23]-ийн магадлан итгэмжлэгдсэн байна.*

2.9 Инженерийн боловсролын сургалтыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх ажиллагааны хүрээнд гадаадын их дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрүүд, гадаад хэл дээр заагдах хичээлийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд 2014 оны байдлаар 2+2 хөтөлбөрөөр (16 хөтөлбөр) 212 оюутан суралцаж ерөнхий эрдмийн хичээлүүдийг хамтарч буй их сургуулийн тухайн орны хэл дээр явуулж байгаагаас гадна инженерийн боловсролыг дэмжих (ЖАЙКА) төслийн хүрээнд Японы Косэн технологийн коллежуудад суралцах оюутнуудын бэлтгэл хөтөлбөрийг нээн хичээллүүлж эхэлжээ.

2.10 Сургуулиуд тодорхой чиглэлүүдээр гарааны компани байгуулахаар инновацийн төслүүд боловсруулж байгаа боловч гарааны компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх, хөрөнгө оруулж хувь эзэмших зэрэг харилцаанд эрх зүйн иж бүрэн зохицуулалтгүйгээс хэрэгжилтийн явц хангалтгүй байна.

2.11 БСШУС-ын 2014 оны А/299, А/359 дугаар тушаалаар Дээд боловсролын мэдээллийн нэгдсэн системийг ШУТИС-ийн UNIMIS системд тулгуурлан байгуулахаар шийдвэрлэсний дагуу 2015 оны эхний хагас жилийн байдлаар 20 гаруй их, дээд сургууль системд нэвтрэх эрхээ авч 45.0 мянга орчим оюутны мэдээллийн нэгдсэн баазыг үүсгэж, сургалтын үйл ажиллагаандаа UNIMIS системийг нэвтрүүлж, хичээлийн хуваарь, хичээл сонголтыг цахимаар хийх боломж бүрдсэн байна.

2.12 2014-2015 оны хичээлийн жилд хийгдсэн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд аудитад хамрагдсан 5 их, дээд сургуулийн 59 бүрэлдэхүүн болон салбар сургуулиудыг 35 болгон цөөлж, нийт орон тоо 0.8 хувиар буурсан боловч 2015-2016 оны хичээлийн жилд өмнөх онтой харьцуулахад 1.3 хувиар нэмэгдсэн байна.

---

*[19] APACC - Asia Pacific Accreditation and Certification Commission (Ази Номхон далайн орнуудын магадлан итгэмжлэлийн холбоо)*
*[20] AMEWPR - Association for Medical Education in the Western Pacific Region (Номхон далайн баруун бүс нутгийн эрүүл мэндийн боловсролын холбоо)*
*[21] ASIIN - Accreditation Agency for Degree Programmes in Engineering, Informatics, the Natural Sciences and Mathematics (Герман улсын Олон улсын дээд боловсролын инженер, мэдээллийн технологи, байгалийн шинжлэх ухаан, математик зэрэг хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн байгууллага)*
*[22] EUR-ACE - Framework Standards for the Accreditation of Engineering Programmes (Европын холбооны олон улсын дээд боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллага )*
*[23] ACBSP - Accreditation Council for Business Schools and Programs (АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн магадлан итгэмжлэх зөвлөл)*

2015-2016 оны хичээлийн жилд суралцагсдын тоо 8.3 хувиар буурсантай холбоотойгоор үндсэн багшийн орон тоо 7.2 хувиар буурсан ч захиргаа, үйлчилгээний ажилтны орон тоо 96 буюу 2.8 хувиар нэмэгдсэн байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт Ж-гээс үзнэ үү)*

Хүснэгт 5. *Орон тооны судалгаа* *(хүний тоо)*

| Ажиллагсдын албан тушаал | Хичээлийн жил | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012-2013 | 2013-2014 | 2014-2015 | Зөрүү 2013/2014 | 2015-2016 | Зөрүү 2014/2015 | Өсөлт, бууралтын хувь |
| Удирдах албан тушаалтан | 234 | 242 | 202 | (40) | 201 | (1) | (0.5) |
| Үндсэн багш | 2,594 | 2,664 | 2,711 | 47 | 2,517 | (194) | (7.2) |
| ЭШ-ний ажилтан | 119 | 113 | 83 | (30) | 98 | 15 | 18.1 |
| Захиргаа, үйлчилгээний | 3,424 | 3,504 | 3,483 | (21) | 3,579 | 96 | 2.8 |
| Нийт орон тоо | 6,371 | 6,523 | 6,479 | (44) | 6,395 | (84) | (1.3) |
| Нийт оюутны тоо | 105,751 | 101,581 | 103,357 | 1,776 | 94,756 | (8,601) | (8.3) |
| Нэг оюутанд ногдох үндсэн багшийн тоо | 0.025 | 0.026 | 0.026 | | 0.027 | | |

2.14 Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд 2014-2015 оны хичээлийн жилд дээрх сургуулиудад зохион байгуулалт, бүтцийн шинэчлэл хийгдсэн ч 2015-2016 оны хичээлийн жилийн дүнгээр суралцагсдын тоо 8.3 хувиар буурч үндсэн багшийн орон тоо 7.2 хувиар буурахад захиргааны ажиллагсдын тоо 2.8 хувиар нэмэгдэж, орон тоо, зардлын хэмнэлт гараагүй нь шинэчлэлтийн үр нөлөөг бууруулж байна.

2.15 Хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар 2015 оны эцэст бүртгэлтэй нийт 32.8 мянган ажилгүй иргэд байгаагаас дээд боловсролтой иргэд 29.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 3.4 хувиар буурчээ.

Хүснэгт 6. *Ажилгүй иргэдийн мэргэшлийн судалгаа* *(хүний тоо)*

| Боловсролын түвшингээр | 2012 он | 2013 он | 2014 он | 2015 он |
|---|---|---|---|---|
| Боловсролгүй | 395 | 323 | 307 | 365 |
| Бага | 1,493 | 1,216 | 789 | 799 |
| Суурь | 5,186 | 4,381 | 2,646 | 2,132 |
| Бүрэн дунд | 14,395 | 18,341 | 15,920 | 15,506 |
| Техникийн болон мэргэжлийн | 2,291 | 2,799 | 2,405 | 2,101 |
| Тусгай мэргэжлийн дунд | 1,989 | 3,718 | 2,581 | 2,073 |
| Дипломын дээд болон бакалавр | 9,879 | 11,738 | 12,017 | 9,478 |
| Магистр | 148 | 256 | 305 | 334 |
| Нийт дүн | 35,776 | 42,772 | 36,970 | 32,788 |

2.16 Хөдөлмөрийн судалгааны институтээс 2015 онд хийсэн судалгаагаар *"Ажил мэргэжлийн үндсэн бүлгийн байдлаар нийгэм, эдийн засаг, бизнес удирдлага гэсэн мэргэжлүүдээр ажиллах хүчний нийлүүлэлтийн илүүдэл үүссэн бөгөөд эдгээр ажил мэргэжлийн нийлүүлэлт нь бараг бүхэлдээ дээд боловсролын байгууллагаас нийлүүлэгдэж байна*" гэж дүгнэсэн байна.

2.17 БСШУЯ-наас хөдөлмөрийн зах зээлийн хэтийн төлөв, эрэлт хэрэгцээ, төгсөгчдийн ажил эрхлэлтийн талаарх мөшгих судалгааны дүн зэрэгт үндэслэн элсэлт авах мэргэжил, суралцагсдын тоог ойрын болон дунд хугацаанд тооцож төлөвлөх талаар авч хэрэгжүүлж буй ажил хангалтгүй, нөгөө талаас ЭЕШ-ийн босго оноог бууруулах замаар элсэлтийн тоог нэмэх арга хандлага ТӨИДС-иудын үйл ажиллагаанд түлхүү ажиглагдаж байгааг анхаарах шаардлагатай байна. Тухайлбал, БСШУС-ын 2014 оны А/143 дугаар тушаалаар 2014-2015 оны хичээлийн жилд элсэлтийн босго оноог 400 буюу түүнээс дээш байхаар тогтоон албажуулж, мөрдөн ажиллахыг их, дээд сургууль, коллежийн захирлуудад үүрэг болгосон байна.

Элсэгчдийн дийлэнх буюу 52.5-67.3 хувь “*Өөрийн хүсэл сонирхлын дагуу*”, 11.2-19.9 хувь “*Элсэлтийн босго оноо, дүн сургуулийн шаардлагыг хангаж байсан*” гэсэн шалтгаанаар тухайн сургууль, төгсөж буй мэргэжлээ сонгож байгаа[24] нь их, дээд сургуулиуд тухайн мэргэжлийн хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварын талаар хангалттай мэдээллийг сонирхогчдод хүргэхгүй байгааг харуулж байна.

2.19 Их, дээд сургууль төгсөгчдөөс жилд дунджаар 12.5 хувь нь дахин суралцдаг бөгөөд түүнд бакалавраар төгсөгчдийн 48.9 хувь нь огт өөр мэргэжлээр суралцаж байгаагаас харахад мэргэжлийн сонголтоо оновчтой хийж чадаагүй байна.

2.20 БСШУЯ нь элсэлтийн хяналтын тоо буюу тухайн хичээлийн жилд элсүүлэх суралцагчийн тооны дээд хязгаарыг мэргэжил, сургууль тус бүрээр батлан зохицуулалт хийж буй хэдий ч уг хяналтын тоог мөрдөж буй эсэхэд тавих хяналт хангалтгүй, зарим сургуулиуд хяналтын тооноос хэтрүүлэн элсүүлж байгаа нь зохицуулалт оновчгүй, тооцоо, судалгааны үр дүн хангалтгүйг харуулж байна.

2.21 Түүнчлэн ТӨИДС-иудыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах Удирдах зөвлөл дэх төрийн төлөөлөл 51-60 хувь байхаар хуульчилж хэрэгжүүлсэн боловч Удирдах зөвлөлийн чиг үүрэг хэрхэн үр нөлөөтэй хэрэгжсэн гэдгийг үнэлэх тогтолцооны хөгжил сул, БСШУЯ болон бусад төрийн захиргааны төв байгууллагуудын зарим нэг удирдах албан тушаалтнууд ТӨИДС-иудын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа хэдий ч төрийн төлөөллийг хэрхэн хэрэгжүүлж ажилласан гэдгийг дэмжих нотолгоо үндсэндээ алга байна. Тухайлбал,

*БСШУЯ-наас:*
- *Төрийн нарийн бичгийн дарга 3 их сургуулийн;*
- *Дээд боловсролын хэлтсийн дарга 4 их сургуулийн;*
- *Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга 4 их сургуулийн;*
- *Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга 3 их сургуулийн;*
- *Соёлын бодлого, зохицуулалтын газрын дарга 2 их сургуулийн;*
- *Инноваци, өндөр технологийн газрын дарга 2 их сургуулийн;*

*Бусад:*
- *Нийслэлийн ЗД-ын Хот байгуулалт, хөрөнгө оруулалт хариуцсан орлогч 2 их сургуулийн;*
- *Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч 2 төрийн өмчит их, дээд сургуулийн удирдах зөвлөлд тус тус ажиллаж байна.*

2.22 Дээд боловсролын тухай хуульд 2016 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр ТӨИДС-иудын Удирдах зөвлөл дэх төрийн төлөөллийг 30 хувь болгож бууруулсан ч энэ нь удирдлага, хяналтын оновчтой хувилбар болж чадаагүй байгаа тул ТӨИДС-иудын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн дэх төрийн оролцоог хувийн хэвшлээр гэрээгээр гүйцэтгүүлэх[25] замаар төрийн оролцоог багасгах боломжийг[26] судлан цаашид эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

***Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, хэрэгжилтэд тавих хөндлөнгийн хяналт сул, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хангалтгүй байна***

2.23 БСШУЯ-наас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу зарим мэргэжлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, тушаалаар батлуулаагүйгээс суралцагчид батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгүй суралцаж байна. Тухайлбал,

- *МУИС-ийн магистрын 14, докторын 9 мэргэжлийн чиглэл (индекс)-ийн сургалтын хөтөлбөр батлагдаагүй, магистрын 42, докторын 21 сургалтын төлөвлөгөө эцэслэн хянагдаагүй;*
- *Дорнод их сургууль зарим мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн батлуулаагүй;*
- *ТДС нь тухайн мэргэжлийн дагуу багшлах боловсон хүчний нөөц хангалтгүйгээс далайн тээвэр, дотоод шаталтын хөдөлгүүр мэргэжлийн 2 хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулаагүй, хуучин сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт явуулж байна.*
- *БХИС нь бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг захирлын тушаалаар батлаагүй байсан бөгөөд БХИС-ийн захирлын 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/281 дүгээр тушаалыг нөхөн*

---

[24]*Эх сурвалж: Хөдөлмөрийн судалгааны институт, Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа 2014, хуудас 29, Хүснэгт 10*

[25]*Төсвийн тухай хуулийн 30.2.1-д “хувийн хэвшлийн эзэмшиж байгаа техник, технологи, үр ашигтай удирдлагын арга барилыг төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх”*

[26]*Дээд боловсролын байгууллагуудын статус, эрх зүйн орчин, сургалт, судалгаа, инновацийн болон санхүүжилт, тайлагналын хөгжингүй тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрийн өөрчлөлт шинэчлэлийн нэгдсэн бодлого боловсруулан хэрэгжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх замаар дээд боловсролын талаарх төрийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх болон гишүүн сургуулиудын хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой Монголын их, дээд сургуулиудын консорциум нэртэй төрийн бус байгууллага 1995 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж, одоо 53 их, дээд сургуулиудыг эгнээндээ нэгтгэсэн байна.*

*гаргуулсан. "Тусгай мэргэжлийн цэргийн урлаг", "Цэргийн химийн техник, зэвсэг" мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлаагүй байна.*

2.24 МУИС 2015-2016 оны хичээлийн жилийн элсэлтээр магистрын ангид БСШУЯ-наас тусгай зөвшөөрөл олгоогүй мэргэжлийн чиглэлээр элсэлт авч, сургалт явуулж байна. Үүнд: *Газарзүйн мэдээллийн систем* (E07310103), *Монгол хэл уран зохиолын боловсрол* (E01140701), *Биологийн боловсрол* (E01140202) гэсэн мэргэжлээр элсэлт авчээ.

2.25 Зарим сургуулиудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө БШУС (хуучин нэрээр)-ын 2014 оны А/174 дүгээр тушаалаар баталсан бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг бүрэн хангаагүй байна. Тухайлбал,

- *АШУҮИС-ийн бакалаврын зарим мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний "суурь хичээл"-ийн эзлэх хувь 25 хувиас хэтэрч, "Мэргэжил"-ийн хичээлийн эзлэх хувь 45 хувьд хүрэхгүй;*
- *ДИС-ийн бакалаврын 5 хөтөлбөрийн мэдээллийн технологи, бизнесийн удирдлага, багш, мэдээлэл зүйн мэргэжлийн суурь хичээл нийт багцын 25 хувиас хэтэрсэн, мэргэжлийн нийт багц 45 хувьд хүрэхгүй байна.*

2.26 Сургуулиудын хөтөлбөрийн хороодын "*Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага*"-ын дагуу холбогдох чиглэлээр судалгаа хийж хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хагас жил тутам үнэлэн тайлагнаж, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хийх ажил хангалттай түвшинд хийгдэхгүй байна.

2.27 Багшлах боловсон хүчний мэргэшлийн түвшин хангалтгүй байгаа нь БСШУС–ын 2010 оны 26 тоот тушаалаар баталсан "*Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам"*-ын *2.3.3-д "Багш магистраас доошгүй зэрэгтэй байна" мөн сайдын* 2003 оны 139 дүгээр тушаалаар батлагдсан "*Багшид тавигдах нийтлэг шаардлага*"-ын зарим заалтыг хангагдаагүй байна. Тухайлбал,

- *СУИС салбарын онцлог, концертмейстр багш нарын хүрэлцээ хангалтгүй зэргээс шалтгаалан үндсэн багш нарын 16 хувь;*
- *ТДС-ийн нийт багш нарын 13 хувь;*
- *ХСИС-ийн Үндсэн багш нарын 8 орчим хувь;*
- *АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дах салбар сургуулийн багш нарын 7.0 хувь, Говь-Алтай аймаг дах салбар сургуулийн багш нарын 31 хувь;*
- *БХИС-ийн үндсэн багш нарын 4 орчим хувь нь холбогдох түвшний зэрэггүй байна.*

2.28 Салбарын онцлогоос хамааран БШУС-ын 2014 оны А/78 дугаар тушаалаар баталсан мэргэжлийн чиглэлд зарим мэргэжлийг нэмэх шаардлага үүсч байна. Жишээ нь: "*ХСИС-ийн бэлтгэж буй мэргэжлүүд захиалагч агентлагуудын хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж байна уу"* гэсэн асуултад санал асуулгад оролцогчдын 40.5 хувь *"Зарим шаардлагатай мэргэжил (хөтөлбөр)-ийн сургалт явагдахгүй байна"* гэж хариулсан нь мэргэжлийн чиглэл (индекс)-ийг бодит байдалд нийцүүлэн дахин харгалзах шаардлагатайг харуулж байна.

2.28 Стандартчиллын үндэсний зөвлөлөөс 2008-2011 онуудад баталсан Дээд боловсролын мэргэжлийн чиглэлийн стандартууд нь одоо мөрдөгдөж буй хөтөлбөр, төлөвлөгөө хичээлийн агуулгатай зарим талаараа уялдаагүй хоцрогдсон байгааг анхаарч БСШУЯ арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

***Санал асуулгын дүн:*** *Аудитын явцад 1,882 багш, ажилтан, 4,709 оюутан "Сургалтын хөтөлбөр зохих стандарт шаардлагыг хангадаг уу?" гэсэн асуулгад 69.0 хувь нь "үгүй" буюу "зарим талаар" гэж хариулсан бөгөөд ярилцлагаар багш, оюутнууд харилцан адилгүй ойлголттой, байгаа нь сургалтын хөтөлбөрийг байнга шинэчилж боловсронгүй болгож байх шаардлагатай гэж дүгнэхэд хүргэж байна. (Дэлгэрэнгүйг хавсралт Д-гээс үзнэ үү)*

***галтыг үр нөлөөтэй явуулах материаллаг бааз, шинэ орчин бий болгох чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлжээ***

2.29 Зарим ТӨИДС-иудын хичээлийн байр зориулалтын бус, барилгын ашиглалтын хугацаа дууссан, "*...цаашид сургалтын зориулалтаар ашиглах боломжгүй*" гэсэн дүгнэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас өгсөн байна. Тухайлбал,

- *ШУТИС-ийн оюутны 2-р дотуур байр 1981 онд ашиглалтанд орж, 2002, 2010 онд их засвар, буурь хөрс, барилгын суурь, голын хананuудад хүчитгэл, гадна ханаы 2 түвшинд төмөр тросоор хүчитгэл хийсэн боловч барилгын даацын үндсэн хийц бүтцэд эвдрэл, гэмтэл үүссэн байгаа тул ашиглалтыг 2010 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зогсоох акт гарсан байна.*
- *СУИС нь хичээлийн 5 байртай бөгөөд бүгд зориулалтын бус, 1954, 1956 онд ашиглалтад оржээ.*
- *СУИС-ийн хичээлийн төв байрны барилгын ашиглалтын төлөв байдалд НМХГ-ын 2010, 2011 онд хийсэн дүгнэлт, зураг төсөл, оношлогооны "Реконстракшн" төвийн 2013 онд хийсэн судалгаагаар "... цаашид хичээлийн байрны зориулалтаар ашиглах боломжгүй болсон байна" гэсэн дүгнэлтийг өгсөн.*
- *ТДС-ийн хичээлийн төв байр 59 жил ашиглагдсан, холбогдох стандарт, шаардлагад нийцэхээргүй хуучирсан байна.*

2.30 Багш, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор сургалтын зориулалттай газрын зориулалтыг өөрчлүүлж, орон сууцны барилга бариулснаар хичээлийн болон дотуур байрыг өргөтгөх, суралцах орчин хумигдах эрсдэлтэй байна. Тухайлбал,

- *ХСИС нийт 168 айлын орон сууцны 4 барилга баригдсанаас 11,926 м² талбай хасагдсан бөгөөд дахин багш, ажилтнуудын орон сууц нэмж барихаар төлөвлөж НЗД-ын 2015 оны А/680 тоот захирамжаар 1,655 м² талбайн газрын зориулалтыг орон сууцны зориулалтай болгон өөрчилсөн байна.*
- *ШУТИС нийт 270 айлын 5 орон сууц баригдсанаас 6.6 га-гаар;*
- *ХААИС нийт 250 айлын 2 орон сууц баригдсанаас 330 м² талбай (барилгын суурийн талбай);*
- *ТДС нийт 400 айлын 2 орон сууц баригдсанаас 828 м² талбай (барилгын суурийн талбай) тус тус хасагдсан.*

2.31 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ХСИС 300 оюутны дотуур байр, 3000 сонсогчийн хичээлийн байр, АШУҮИС, МУБИС номын сангийн байрыг улсын төсвийн болон өөрийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулжээ.

2.32 Хичээлийн болон дотуур байрны урсгал болон их засвар, лаборатори сургалтын тоног төхөөрөмж худалдан авахад улсын төсөв, АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөс санхүүжилт олгосон нь судалгаа, эрдэм шинжилгээний шинэ орчин бүрдэхэд зохих хэмжээгээр нөлөө үзүүлж байна. Үүнд:

- *ШУТИС - ҮТС-ийн Хувцас судлалын төвийн дэргэд хүний биеийн 3D хэмжилтийн лаборатори;*
- *ШУТИС -Хүнсний молекул биологийн судалгааг олон улсын стандартын түвшинд гүйцэтгэж улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах Хүнс судлал, биотехнологийн иж бүрэн лаборатори;*
- *АШУҮИС – тус салбарт эсийн өсгөвөр, молекул биологи, нуклейн хүчил, уургийн болон химийн анализ, эмгэг судлал, амьд эсийн дүрслэл, туршилтын амьтны лаборатори гэсэн чиглэлээр олон улсын жишигт хүрэхүйц эрдэм шинжилгээ, инновацийн судалгааны ажлыг хэрэгжүүлэх бүрэн боломж бүхий "Цөм лаборатори";*
- *ХААИС - Мал аж ахуй, биотехнологийн сургуульд Байгаль шинжлэл, биохими, Геномиксийн лаборатори;*
- *МГХТДС - Физикийн лаборатори, химийн лаборатори, мэргэшүүлэх лаборатори.*

2.33 Лаборатори байгуулах, сургалтын орчинг сайжруулах чиглэлээр их, дээд сургуулиудад сүүлийн 3 жилд дараах санхүүжилтийг олгожээ.

Хүснэгт 4. *Лаборатори байгуулах чиглэлээр олгосон санхүүжилт* *(сая төгрөг)*

| Төслийн нэр | 2013 он | 2014 он | 2015 он |
|---|---|---|---|
| Дээд боловсролын шинэчлэл төсөл | 197.7 | 8,611.2 | 2,848.2 |
| Улсын төсвөөс их, дээд сургуулийг дэмжих чиглэлээр хийгдсэн хөрөнгө оруулалт | 3,361.2 | 5,626.3 | 1,052.9 |
| Нийт | 3,558.9 | 14,237.5 | 3,901.1 |

Мөн гадаад орнуудаас хэрэгжүүлж буй төсөл, зээл тусламжийн хүрээнд орчин үеийн тоног төхөөрөмж бүхий лабораториуд байгуулагдаж судалгаа, шинжилгээ явуулах материаллаг орчинг бүрдүүлжээ. Тухайлбал,

- *ХААИС - Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, үнэлгээний лаборатори, Сүү судлалын лаборатори, Амьтны биотехнологи, Мах боловсруулах лаборатори, Мах судлалын лаборатори, Бүрэн автомат гидропоник 2 хүлэмж (КОЙКА-гийн санхүүжилтээр);*
- *ШУТИС - ХБНГУ-ын Кемницийн ТИС-ийн хөрөнгө оруулалтаар ЭХИС-д байгуулагдах хоёр лабораторийн эхний хэсэг болох "Raspberry Pi" лаборатори, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль КОЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтарсан хөрөнгө оруулалтаар Эрчим хүчний сургалтын орчинг сайжруулах зорилго бүхий "Хүчний электроник хувиргах техникийн лаборатори", Польш улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Машин механизмын лабораторийн шинэчлэл өргөтгөл;*
- *МУИС – Германы Эрдмийн Солилцооны Алба (DAAD) биоорганизмын генийн олон янз байдлыг хоёр үндсэн чиглэлээр судлах Молекул-Экологийн лабораториуд байгуулагдсан.*

2.35 Зарим сургуулиудын дотуур байрны хүрэлцээ, орчин нөхцөлийг сайжруулах талаар арга хэмжээ авах шаардлага үүссэн байна. Дотуур байранд урсгал засвар жил бүр хийгддэг боловч агааржуулалтын систем муу, нэгдсэн гал тогоо, угаалгын өрөөгүй, тааз хананы будаг шохой ховхорч унасан, бүгчим чийгшил ихтэй зэрэг нь оюутны амьдрах орчин, нөхцөлд муугаар нөлөөлж байна.

2.36 Мөн оюутны дотуур байруудад гадны суугчид, багш, ажилтнууд амьдарч байгаагаас хөдөө орон нутгийн оюутнууд дотуур байранд бүрэн хамрагдах боломжгүй байна.

***Санал асуулгын дүн:*** *Аудитын явцад 2.295 багш, ажилтан, оюутан "Сургуулийн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний материаллаг орчин хангалттай уу?" гэсэн асуулгад 31.6 хувь нь "тийм", 41.5 хувь нь "зарим талаар" гэж хариулснаас үзэхэд материаллаг орчин тодорхой хэмжээнд сайжирсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт Д-гээс үзнэ үү)*

***Дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог төлөвшүүлэх, хэрэгжүүлэх талаар сургуулиудын удирдлагын зүгээс хангалтгүй ажиллаж байна***

2.37 Зарим их дээд сургуулиудад дотоод аудитын нэгж ажиллахгүйгээс өнөөгийн бүтэц нь санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад тавигдах дотоод хяналт үйлчлэхгүй байна. Тухайлбал,

- *МУИС-ийн Захиргаа, хяналт – шинжилгээ, үнэлгээний алба нь мэргэшсэн ажилтангүй;*
- *ХААИС нь 2015 оны 4 дүгээр сараас дотоод аудиторыг авч ажиллуулсан боловч тогтвортой ажиллаагүй;*
- *ХСИС нь 2013-2015 он хүртэлх хугацаанд мэргэшсэн ажилтангүй;*
- *Ховд их сургууль нь Дотоод аудитороор Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш Н.Батжаргалыг томилсон ч тухайн чиглэлээр хяналт хийгдээгүй байна.*

2.38 Сургуулиудын дотоод хяналт, дотоод аудитын нэгж нь тухайн албаныхаа бүрэлдэхүүнд үйл ажиллагаа явуулж байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "*Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам*"-ын 3.2[27]дах заалттай нийцэхгүй байна. Тухайлбал,

- *ШУТИС-ийн дотоод аудиторууд нь Захиргаа, мониторингийн газрын бүтцэд;*
- *ХСИС-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь Захиргааны удирдлагын газрын бүтцэд;*
- *ХААИС-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж нь захиргааны албаны бүтцэд харьяалагддаг.*

2.39 Их, дээд сургуулиудын дотоод хяналт, шалгалтын хүрээнд мөрдөж буй дүрэм журмуудыг шинэ орчин нөхцөл, хүлээн зөвшөөрөгдсөн байх нийтлэг шаардлагад нийцүүлэн өөрчлөн шинэчлэх шаардлагатай байна.

2.40 Дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагаа санхүүгийн болон сургалтын үйл ажиллагааг бүрэн хамарч чадахгүй байгаагаас их, дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүнгийн талаар иж бүрэн, үнэн зөв мэдээллээр хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

---

[27] *3.2-т Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна*

Зарим их, дээд сургуулийн удирдлага хөндлөнгийн болон дотоод хяналтын тайланг захиргааны зөвлөлөөр авч хэлэлцдэггүй, өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлж буй арга хэмжээ үр дүн муутай байна. Тухайлбал,

- *Дорнод их сургуульд аймгийн МХГ-аас 2013-2015 оны хичээлийн жилд 2 удаагийн хяналт, шалгалт зохион байгуулж, сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөр, төлөвлөгөө, багшлах боловсон хүчний боловсролын зэрэгтэй холбоотой 8 төрлийн зөрчил илрүүлж зөвлөмж өгснөөс, 7 зөвлөмжийг хэрэгжүүлж , магистр, докторын хөтөлбөрүүдийг боловсруулж, батлуулах тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;*
- *ШУТИС-ийн Дотоод хяналт шалгалтын журмын 5.1-д “Дотоод хяналт шалгалтын үр дүнг Ректорын зөвлөл болон захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж зохих шийдвэрийг гаргуулна” гэж заасан ч Ректорын зөвлөл нь зарим хяналт шалгалтын дүнг хэлэлцэж тодорхой шийдвэр гарган ажиллаагүй;*
- *МУИС-д дотоод аудитын тогтолцоо бүрдүүлэх талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.*

2.42 Аудитын явцад их, дээд сургуулиудын захиргааны ажилтнууд, багш нараас авсан санал асуулгын “*Сургуулийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн болон дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгждэг үү?”* гэсэн асуултад оролцогчдын 48.8 хувь *“мэдэхгүй”*, 14.3 хувь *“үгүй”* гэсэн хариултыг өгчээ.

2.43 Энэ нь ТӨИДС-ийн санхүүгийн үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд тавих хөндлөнгийн болон дотоод хяналт шалгалтын үр дүнгийн талаар дийлэнх багш, ажилтнууд анхаарал хандуулдаггүй, сургуулийн захиргаанаас хэрэгжүүлсэн гэх ажлын болон түүний үр нөлөө хангалтгүй, нээлттэй ил тод бус байгааг харуулж байна.

***Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна***

2.44 Шилэн дансны тухай хуулийн 5.1-д “*Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна*”, 5.1.1-д *“шилэн дансны бие даасан цэстэй байх”* гэж заасны дагуу сургуулиуд цахим хуудастаа мэдээлэл байршуулах цэс нээсэн боловч мэдээллийг байршуулах ажлын явц нийт сургуулиудын хэмжээнд хангалтгүй хийгдсэн байна.

2.45 Ямар мэдээллийг хэдий хугацаанд байршуулах талаар ажилтнуудад мэдлэг, мэдээлэл хомс, хуулийг хэрэгжүүлж байгаа эсэх талаар дээд шатны байгууллага, сургуулиудын дотоод хяналт, аудиторууд хяналт тавьдаггүйгээс цэс нээх, худалдан авах ажиллагааны зарим цөөн тооны мэдээллийг оруулах төдийгээр хэрэгжилт нь хязгаарлагдаж, үр нөлөөтэй бус байгаад анхаарч хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг олон нийтэд ил тод болгох шаардлагатай болжээ.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- УИХ-ын баталсан "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого", Засгийн газрын баталсан "Боловсрол" үндэсний хөтөлбөр, салбарын сайдын баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл (хөтөлбөр) индекс" зэрэг бодлого, хөтөлбөрийн хүрээнд ТӨИДС-иуд тус тусын үйл ажиллагааны стратеги, шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа боловч үр дүнг үнэлж дүгнэх хяналт сул, сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хангалтгүй байна.
- ТӨИДС-иудад 2015-2016 онд зохион байгуулалт, бүтцийн шинэчлэлт хийгдсэн боловч суралцагсдын тоо 8.3 хувь, үндсэн багшийн орон тоо 7.2 хувиар буурсан байхад захиргааны ажиллагсдын тоо 2.8 хувиар нэмэгдэж, орон тоо, зардлын хэмнэлт гараагүй нь шинэчлэлийн үр нөлөөг бууруулж байна.
- ТӨИДС-иудын санхүүгийн гол эх үүсвэр болох сургалтын төлбөр нийт орлогод 65 орчим хувийг эзэлж байгаа бол төсвөөс олгож буй тогтмол зардлын санхүүжилт 4 орчим хувьтай тэнцэж, хөтөлбөр, үйл ажиллагааны бус барилга байгууламж, орон тооны санхүүгийн дэмжлэг болж байна.
- ТӨИДС-иуд сургалтын төлбөрийг жил бүр нэмэгдүүлэх замаар санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээтэй орчинд ажилласан бөгөөд зарим сургуулиуд дээр их хэмжээний мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэл бий болсон байна.
- ТӨИДС-иудын хөрөнгө оруулалт, тогтмол зардлын зарим хэсгийг сургалтын төлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлсэн нь Боловсролын тухай хуулийн 40.2, 40.7, Дээд боловсролын санхүүжилт, суралцагсдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5.5, 5.6 дахь заалттай нийцэхгүй байна.
- Сургалтын төлбөрийг тооцох хуулийн шаардлагад нийцсэн журам, аргачлал байхгүй, дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй, Засгийн газар, салбарын яамны мэргэжил арга зүйн удирдлага, хяналт сулаас ТӨИДС-иудын хамтын болон гүйцэтгэх удирдлага сургалтын төлбөрийг тооцоолох, тогтоох, өсгөж нэмэгдүүлэх, санхүүгийн нөөцийг захиран зарцуулахдаа өөр өөрсдийн бодлого, арга зүйгээр хандаж байна.
- ТӨИДС-иуд сургуулийн эзэмшил газрын зориулалтыг өөрчлүүлж, орон сууцны барилга бариулах тохиолдол нийтлэг байгаа нь багш ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэх зорилготой төдийлөн нийцэхгүй, хичээлийн болон дотуур байрыг өргөтгөх, сургалтын орчин сайжруулах нөхцөл боломжийг хязгаарлаж байна.

Тайлбар 1-ийг үзнэ үү.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
